



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

▶ МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, 2021-2022

Улаанбаатар хот
2024 он

© Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага 2024



Энэхүү хэвлэлийг Creative Commons Attribution 4.0 Олон улсын тусгай зөвшөөрлийн хүрээнд олон нийтэд нээлттэй байршуулсан болно (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>). Тусгай зөвшөөрлийн хүрээнд уг тайланг дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх боломжтой. Ингэхдээ ОУХБ болон Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны хэвлэлийн анхны хувилбарыг эзэмшигч гэдгийг тодорхой тусгаж өгнө. Дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх тохиолдолд ОУХБ болон Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны логог ашиглахыг хориглоно.

Зохиогч – Хэвлэлийг дараах байдлаар эшилнэ: МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР: Судалгааны үр дүн, 2021-2022: Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, 2024.

Орчуулга – Энэхүү хэвлэлийг орчуулсан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулсан байх ёстой: ОУХБ болон МУ-ын ҮСХ нь энэхүү орчуулгыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд эдгээр байгууллагын албан ёсны орчуулга биш юм. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ болон МУ-ын ҮСХ хариуцахгүй.

Өөрчлөлт – Хэвлэлийн агуулгыг өөрчлөн гаргасан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулна: Энэхүү бүтээл нь ОУХБ болон МУ-ын ҮСХ-оос гаргасан зохиогчийн эрх бүхий бүтээлийг өөрчлөн боловсруулсан хувилбар юм. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ болон МУ-ын ҮСХ хариуцахгүй бөгөөд өөрчлөн гаргасан зохиогчид бүрэн хариуцна.

Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөр: Судалгааны үр дүн, 2021-2022, ОУХБ, МУ-ын ҮСХ – Женев, Улаанбаатар, 2024. ISBN: 9789220405963 (хэвлэмэл) 9789220405970 (веб pdf)

Энэ хэвлэлийн англи хэл дээрх хувилбар: Child labour in Mongolia: Survey results 2021–2022, ILO, NSO – Geneva and Ulaanbaatar, 2024. ISBN: 9789220405796 (print); 9789220405802 (web PDF)

ОУХБ болон МУ-ын ҮСХ-ны мэдээллийн сан, хэвлэлд ашиглагдсан энэхүү материал нь ОУХБ-ын болон МУ-ын ҮСХ-ны зүгээс аливаа улс орон, нутаг дэвсгэрийн эрх зүйн байдал, эрх мэдэл, эсвэл тэдгээрийн хил хязгаарын талаарх илэрхийлсэн байр суурь, илэрхийлэл биш болно.

Хэвлэлд тусгагдсан үзэл, санаа бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд ОУХБ болон МУ-ын ҮСХ-ны үзэл, санаа бодол, эсвэл бодлого биш юм.

Байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг эш татах нь ОУХБ-аас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн гэсэн утгыг илэрхийлэхгүй. Мөн бусад байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь хүлээн зөвшөөрөөгүйн шинж биш юм.

Энэхүү судалгааг Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон Америкийн нэгдсэн улсын Хөдөлмөрийн департментын санхүүжилтийн хүрээнд IL-30147-16-75-K-11 (MAP-16 төсөл) хамтын ажиллагааны гэрээний дагуу зохион байгуулав. Энэхүү тайлан нь Америкийн нэгдсэн улсын Хөдөлмөрийн департментын үзэл бодлогыг илэрхийлээгүй, бараа, арилжааны бүтээгдэхүүн, байгууллагын нэрсийг тайланд дурдсан нь АНУ-ын Засгийн газрын дэмжлэгийг хүлээсэн гэдгийг илэрхийлээгүй.

Монгол Улсад хэвлэв.

СУДАЛГААНЫ ТАЙЛАН ХЯНАСАН:

Мария Габриелла Бреглиа Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан хэлтсийн Судалгаа, үнэлгээний албаны Бодлогын судлаач

Гуарселло Лорензо Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан хэлтсийн Судалгаа, үнэлгээний албаны Бодлогын судлаач, статистикч

СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН:

Э.Гантуяа Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн ахлах статистикч

О.Норовсамбуу Үндэсний статистикийн хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Өгөгдөл, судалгаа, шинжилгээний хэлтсийн ахлах статистикч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

📍 Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу
Засгийн газрын III байр

☎ 976-11-326414

🌐 www.nso.mn, www.1212.mn

✉ information@nso.mn



▶ АГУУЛГА

▶ АГУУЛГА	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	8
ӨМНӨХ ҮГ	11
▶ БҮЛЭГ I. ХУРААНГУЙ	14
1.1. Удиртгал	14
1.2. Судалгааны зорилго	14
1.3. Судалгааны товч дүн	14
▶ БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	19
2.1. Эрх зүйн баримт бичиг	20
2.2. Статистикийн ойлголт, тооцоолууд	22
2.3. Судалгааны түүвэрлэлт	25
2.4. Судалгааны асуулгын хуудас, мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	26
▶ БҮЛЭГ III. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	29
3.1. Хүн ам	30
3.2. Эдийн засгийн өсөлт, бүтцийн өөрчлөлт	30
3.3. Ядуурлын түвшин	31
3.4. Тэгш бус байдал	32
3.5. Өрхийн амьжиргаа	33
3.6. Нийгмийн халамж	34
3.7. Хөдөлмөр	34
3.8. Хүний хөгжлийн индекс	35
▶ БҮЛЭГ IV. ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	37
▶ БҮЛЭГ V. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР	45
5.1. Үндсэн ажлын онцлог	49
5.2. Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн ажлын хэлбэр	50
5.2.1. Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлж буй хүүхэд	52
5.2.2. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхэд	56
5.3. Ажлын цаг	59
5.4. Ажлын байрны нөхцөл	61

5.5. Хүүхдийн аюултай ажилд оролцож буй хүүхэд	63
5.6. Хүүхдийн хөдөлмөрийн улирлын хэлбэлзэл	67
▶ БҮЛЭГ VI. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТ ОРОЛЦОЖ БУЙ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ	71
6.1. Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал	72
6.2. Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн сургуульд хамрагдалт	74
▶ БҮЛЭГ VII. ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ХАНДЛАГА, ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТ НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ	77
7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааны чиг хандлага	78
7.2. Хүүхдийн хөдөлмөрт нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ	79
▶ БҮЛЭГ VIII. ХҮҮХДИЙН ГЭРИЙН АЖИЛ, ЧӨЛӨӨТ ЦАГ	83
8.1. Гэрийн ажлын оролцоо	84
8.2. Гэрийн ажил болон хүүхдийн хөдөлмөр	87
▶ БҮЛЭГ IX. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТЭЙ ТЭМЦЭХ ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУД, ЗӨВЛӨМЖ	89
Хавсралт 1. Ойлголт, тодорхойлолт	93
Хавсралт 2. Судалгааны түүврийн арга зүй	96
Хавсралт 3. Статистик хүснэгт	99
Хүүхдийн хөдөлмөрийн стандарт алдаа ба итгэх интервал	99
Статистик хүснэгтүүд	103
Хавсралт 4. Судалгааны асуулга	121

▶ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1. Хүүхдийн хөдөлмөрийн статистик үзүүлэлтийг тодорхойлох арга зүйн хүрээ	24
Хүснэгт 3.1. Тэгш бус байдал	32
Хүснэгт 3.2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт, мянган хүн	34
Хүснэгт 3.3. Хүний хөгжлийн индекс	36
Хүснэгт 4.1. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхэд, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр	39
Хүснэгт 4.2. 6-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагаа, хүйс, байршлаар	43
Хүснэгт 5.1. Хүүхдийн хөдөлмөр, ажлын хэлбэрээр, насны бүлэг, хүйс, байршлаар	51
Хүснэгт 5.2. Цалин хөлс, орлого олох зорилготой хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагаа, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр	53
Хүснэгт 5.3. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхэд, үйл ажиллагааны төрөл, хүйс, байршил, хувиар	57
Хүснэгт 5.4. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан долоо хоногийн дундаж цаг, насны бүлэг, ажлын хэлбэр, хүйс, байршлаар	60
Хүснэгт 5.5. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, сургуульд хамрагдалтын байдлаар	61
Хүснэгт 5.6. Хүүхдийн хөдөлмөр, улирал, хүйс, насны бүлэг, байршлаар	68
Хүснэгт 6.1. Хүүхдийн хөдөлмөр, өрхийн тэргүүлэгчийн хүйс, ам бүлийн тоогоор	72
Хүснэгт 7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, судалгаа явуулсан оноор	79
Хүснэгт 7.2. Ложистик регрессийн шинжилгээнд ашигласан хувьсагч, түүний тайлбар	80
Хүснэгт 7.3. Хүүхдийн хөдөлмөрт нөлөөлсөн хүчин зүйлсийн стэпвайс ложистик регрессийн шинжилгээний маржинал эффект	81
Хүснэгт 7.4. Хүүхдийн аюултай ажилд нөлөөлсөн хүчин зүйлсийн стэпвайс ложистик регрессийн шинжилгээний маржинал эффект	81
Хүснэгт 8.1. Гэрийн ажилд оролцсон, аюултай байж болзошгүй гэрийн ажилд оролцсон хүүхэд, хүйс, насны бүлэг, байршлаар	84
Хүснэгт 8.2. Гэрийн ажил хийсэн хүүхэд, хүүхдийн хөдөлмөрт оролцдог эсэхээр	87

► ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	Ажил, түүний хэлбэр	22
Зураг 2.2.	Хүүхдийн хөдөлмөр, ажлын хэлбэрээр	23
Зураг 3.1.	Хүн амын нас хүйсийн суварга	30
Зураг 3.2.	Хүн ам зүйн ачаалал, хувиар	30
Зураг 3.3.	Эдийн засгийн өсөлт, бууралт, хувиар	31
Зураг 3.4.	Ядуурлын хамралтын хүрээ болон ядуу хүн амын тоо, улсын дунджаар	31
Зураг 3.5.	Ядуурлын хамралтын хүрээ, хувиар, ядуу хүн амын тоо, байршлаар	32
Зураг 3.6.	Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 5 бүлгээр, дүнд эзлэх хувиар	33
Зураг 3.7.	Өрхийн сарын дундаж бодит орлогын өсөлтийн хувь (%), (2010=100)	33
Зураг 3.8.	Өрхийн сарын дундаж бодит орлогын өсөлт, эдийн засгийн өсөлт, хувиар	33
Зураг 3.9.	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, жилээр, мянган хүн	34
Зураг 3.10.	Хөдөлмөр эрхлэлтийн болон ажилгүйдлийн түвшин, хүйсээр, хувиар	35
Зураг 3.11.	Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар	35
Зураг 4.1.	5-17 насны хүүхдийн эдийн засгийн оролцоо	38
Зураг 4.2.	5-17 насны хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа	38
Зураг 4.3.	Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, нас, хүйсээр	39
Зураг 4.4.	Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, нас, байршлаар	40
Зураг 4.5.	Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, хүйс, байршил, насны бүлгээр	40
Зураг 4.6.	Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхэд, насны бүлэг, аймгаар	41
Зураг 4.7.	5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхэд, ажлын хэлбэр, хүйс, байршил, насны бүлгээр	41
Зураг 4.8.	Хүүхдийн сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагааны оролцоо, насны бүлгээр	42
Зураг 4.9.	Хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагаа, насаар	43
Зураг 5.1.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр	46
Зураг 5.2.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, аймаг, нийслэлээр	47
Зураг 5.3.	Хүүхдийн хөдөлмөр, ангиллаар	47
Зураг 5.4.	Хүүхдийн хөдөлмөр, нас, хүйс, дүнд эзлэх хувиар	48
Зураг 5.5.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, нас, хүйсээр	48
Зураг 5.6.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, байршлаар	49
Зураг 5.7.	Хүүхдийн хөдөлмөр, эдийн засгийн үндсэн үйл ажиллагааны салбар, дүнд эзлэх хувиар	49

Зураг 5.8.	Хүүхдийн хөдөлмөр болон ажлын хэлбэр	52
Зураг 5.9.	Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, дүнд эзлэх хувиар	54
Зураг 5.10.	Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд, статус, хүйс, байршил, насны бүлэг, хувиар	55
Зураг 5.11.	Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн сарын дундаж цалин, орлого, хүйс, байршил, насны бүлэг, хувиар	55
Зураг 5.12.	Хүүхдийн цалин хөлс, орлого олох ажилд зарцуулсан цаг, салбар, хүйс, байршил, насны бүлгээр	56
Зураг 5.13.	Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн сургуульд хамрагдалт, хувиар	56
Зураг 5.14.	Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхэд, үйл ажиллагааны төрөл, насны бүлэг, дүнд эзлэх хувиар	58
Зураг 5.15.	Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхдийн долоо хоногт зарцуулсан дундаж цаг, үйл ажиллагааны төрөл, хүйс, байршил, насны бүлгээр	58
Зураг 5.16.	Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, байршил, насны бүлгээр, хувиар	59
Зураг 5.17.	Долоо хоногийн дундаж цаг, хүйс, байршил, насны бүлгээр	59
Зураг 5.18.	Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан долоо хоногийн дундаж цаг, ҮТС үйлдвэрлэлийн хүрээнд, цагийн интервалиар, хувиар	60
Зураг 5.19.	Ажлын нөхцөл, тулгарсан хүндрэлээр	62
Зураг 5.20.	Хүүхдийн хөдөлмөрт оролцох явцдаа осол, гэмтэл авсан тохиолдол, төрлөөр	62
Зураг 5.21.	Хүүхдийн хөдөлмөрт оролцох явцдаа өвдсөн тохиолдол, үүссэн өвчнөөр	63
Зураг 5.22.	Хүүхдийн аюултай ажилд оролцсон хувь, хүйс, насны бүлэг, байршлаар	64
Зураг 5.23.	Хүүхдийн аюултай ажилд оролцсон хувь, аймаг, нийслэлээр	64
Зураг 5.24.	Хүүхдийн аюултай ажил, аюултай байдлын хэлбэрээр	64
Зураг 5.25.	Хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд, салбар, мэргэжил, хүйсээр	65
Зураг 5.26.	Хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд, салбар, мэргэжил, насны бүлэг, байршил, дүнд эзлэх хувиар	65
Зураг 5.27.	Хэт их цагаар хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд, ажлын хэлбэрээр, дүнд эзлэх хувиар	66
Зураг 5.28.	Хэт их цагаар хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн хувь	66
Зураг 5.29.	Ажлын байрны аюултай нөхцөлд хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд, ажлын нөхцөлөөр	67
Зураг 5.30.	Хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн аюултай ажилд оролцсон хувь, улирлаар	68
Зураг 5.31.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, хүйс, улирлаар	68
Зураг 5.32.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, байршил, улирлаар	69
Зураг 5.33.	Хүүхдийн хөдөлмөр, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, мянган хүүхдээр	69
Зураг 5.34.	Хүүхдийн хөдөлмөр, ажлын хэлбэр, улирлаар, мянган хүүхдээр	70

Зураг 5.35.	Хүүхдийн хөдөлмөр, ангилал, улирлаар, мянган хүүхдээр	70
Зураг 6.1.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, өрхийн тэргүүлэгч, ам бүлээр	72
Зураг 6.2.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин, аав, ээжтэйгээ амьдардаг эсэхээр	73
Зураг 6.3.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, өрхийн сууц, усан хангамжийн төрлөөр	73
Зураг 6.4.	Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, өрхийн сарын дундаж орлогоор, хямралд өртсөн өрх эсэхээр	74
Зураг 6.5.	Сургуульд хамрагдалтын хувь, хүүхдийн хөдөлмөрт хамрагдалтаар, насаар	75
Зураг 6.6.	Сургуульд хамрагдалтын хувь, хүйс, насаар	75
Зураг 6.7.	Өмнөх хичээлийн жилд суралцаагүй шалтгаан	76
Зураг 7.1.	Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, нийт хүүхдэд эзлэх хувь, судалгаа явуулсан оноор	78
Зураг 7.2.	Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, судалгаа явуулсан оноор	78
Зураг 8.1.	Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, нийт хүүхдэд эзлэх хувиар	84
Зураг 8.2.	Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, үйл ажиллаг, хүйсээр, хувиар	85
Зураг 8.3.	Хүүхдийн аюултай байж болзошгүй гэрийн ажил эрхлэлтийн түвшин, хүйс, нас, байршлаар	85
Зураг 8.4.	Аюултай нөхцөлд гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, нийт гэрийн ажил эрхэлсэн хүүхдэд эзлэх хувиар, ажлын төрлөөр	86
Зураг 8.5.	Гэрийн ажилд зарцуулсан дундаж цаг, үйл ажиллагаагаар	87
Зураг 8.6.	Гэрийн ажил хийсэн хүүхэд, хүүхдийн хөдөлмөрт оролцсон эсэхээр, дүнд эзлэх хувиар	88

▶ ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХС	Ажиллах хүчний судалгаа
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХСБХ	Олон улсын хөдөлмөрийн статистикчдын бага хурал
ӨНЭЭС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮНБ	Үндэсний нийт бүтээгдэхүүн
ҮТС	Үндэсний тооцооны систем
ХА	Хүн ам
ХАА	Хөдөө аж ахуй
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан
ХХС	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа
ХЭК	Хүний эрхийн конвенц
ЯШ	Ядуурлын шугам



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа дахь оролцоо нь хүүхдийн хөдөлмөр мөн эсэх нь хүүхдийн нас, ажлын цаг, нөхцөл, гүйцэтгэж буй ажлын төрлөөс хамаарна. Хэрвээ хүүхэд бага наснаасаа, урт цагаар эсвэл бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, хөгжил, боловсорч сурахад нь нөлөөлөхүйц ажилд оролцдог бол энэ нь хүүхдийн хөдөлмөр болно.



Монгол Улсад **138 мянга гаруй хүүхэд хүүхдийн хөдөлмөрт оролцож** байна.



37.4%
Охид



62.6%
Хөвгүүд

Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй нийт хүүхдийн тоо: 37.4% нь охид, 62.6% нь хөвгүүд



5-17 насны хүүхдийн **16.3%**

Бүх насны бүлэгт **хөвгүүд** охидтой харьцуулахад илүү хөдөлмөр эрхэлж байна.



Хөдөөд хүүхдийн хөдөлмөр их байна.



Монгол хүүхдүүд хөдөлмөрийн зах зээлд эрт орж байна: 5-12 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт 16.8%




АЮУЛТАЙ АЖИЛ

Хүүхдийн аюултай ажил гэж хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх аюултай шинж чанар бүхий (аюултай орчин, тоног төхөөрөмж, салбар, ажил мэргэжил) аливаа ажил, үйл ажиллагаа юм.




Хөвгүүд охидыг бодвол аюултай ажилд илүү оролцож байна.

Аюултай ажилд оролцож буй хүүхдийн дийлэнх нь **хөдөө** амьдарч байна.



Ажил хийж буй хүүхдүүдийн ихэнх нь том мал, тэжээвэр амьтадтай харьцаж эсвэл өтөг, бууц, ялгадастай орчинд ажиллаж байсан тул хүүхдийн аюултай ажилд оролцсонд тооцсон.

Аюултай ажилд оролцож буй 10 хүүхэд тутмын 1 нь ажил, мэргэжлийн хувьд аюултайд тооцогдож, тэдгээрийн 2.0 мянга (40.8%) нь барилгын салбарт дотоод засал, чимэглэлийн ажил туслах, барилгын материал, багаж хэрэгсэл зөөх гэх зэрэг барилгын туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцжээ.



► ӨМНӨХ ҮГ

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрээс урьдчилан сэргийлэх тухай дэлхийн санаачилга 1999 онд гарснаас хойш Монгол Улс хүүхдийн хөдөлмөрийн эсрэг үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэхэд ихээхэн ахиц дэвшил гаргасан юм.

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар конвенц, Ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцыг тус тус соёрхон баталж, хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэр түүний дотор хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах улс төрийн амлалт авсан билээ.

Монгол Улсын Засгийн газар, ажил олгогч, ажиллагчид гэсэн гурван талт түншүүд хууль эрх зүйн болон зохион байгуулалтын хүрээнд томоохон ахиц дэвшил гаргасан, хамгийн сүүлд гэхэд 2021 онд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, насанд хүрээгүй хүмүүст хориглосон ажлын жагсаалт, хөнгөн ажлын тодорхойлолтыг батлав.

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо нь 2002-2003 оноос хойш хүүхдийн хөдөлмөрийн талаарх өгөгдөл, баримтыг цуглуулж, нотолгоонд суурилсан арга хэмжээ, бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангаснаар хүүхдийн хөдөлмөрийг устгах үндэсний энэхүү амлалтад үнэтэй дэмжлэг үзүүлж ирсэн.

Энэхүү тайлан нь Монгол Улсад явуулсан Хүүхдийн хөдөлмөрийн дөрөв дэх судалгааны үр дүн юм. Тайланд дурдсан хүүхдийн хөдөлмөрийн үзүүлэлтүүд нь 2018 оны 10-р сард болсон Олон улсын хөдөлмөрийн статистикчдийн 20 дугаар бага хурлаас баталсан хүүхдийн хөдөлмөрийн хамгийн сүүлийн олон улсын статистик хэмжилтийн стандарттай нийцэж байгаа болно. Хүүхдийн хөдөлмөрийн шинж чанарыг хянах, ойлгоход зайлшгүй шаардлагатай хүүхдийн хөдөлмөрийн талаарх найдвартай, цогц өгөгдөл цуглуулах Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны хүчин чармайлтыг ОУХБ өндрөөр үнэлж байгаагаар илэрхийлж байна. Энэхүү судалгааны үр дүн нь хүүхдийн хөдөлмөрийг устгаж, бүх хүүхдийг чанартай боловсролд хамруулах, залуучуудыг өөрсдийн бүтээмж, бүтээлч чадавхаа хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтад хамруулахад хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.



Чанхи Ли

ОУХБ-ын БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчооны захирал



Филипп Ванхейнегем

ОУХБ-ын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан салбарын захирал

▶ ӨМНӨХ ҮГ

Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагаас баталсан Хүүхдийн эрхийн конвенцод 1990 онд, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар конвенцод 1999 онд, Ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцод 2002 онд нэгдэн орж, хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгах болон хүүхдийг хүнд хортой нөхцөлийн ажил, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт татан оруулахыг хязгаарлах, таслан зогсооход чиглэсэн үндэстний хэмжээний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулж ирсэн. Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейгаас албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг устгах хүчин чармайлтыг уриалж, 2021 оныг Хүүхдийн хөдөлмөрийг устгах жил болгон зарласан. Ийнхүү хүүхдийн хөдөлмөрийг устгах хүчин чармайлтыг нэмэгдүүлэх нь зөвхөн хүний эрхийг хангах төдийгүй улс орны тогтвортой хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой. Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейгаас 2015 онд бүх нийтийн, хүртээмжтэй, хуваагдал, ялгаварлалгүй байх гол зарчмыг агуулсан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг баталж, хүн бүрийн амьдралыг сайжруулж, хөгжлийн гадна нэг ч хүнийг үлдээхгүйгээр томоохон өөрчлөлт хийхийг бүх улс орнуудад уриалсан.

Монгол Улсын төр засаг дэлхий нийтийн энэхүү уриалгад нэгдэн орж хүүхдийн хөдөлмөрийг хориглох, устгахын төлөө тууштай ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлаар 2016 онд “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ыг батлан, Тогтвортой хөгжлийн зорилгын 8.7-р зорилтоор “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэлээр шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авч, албадан хөдөлмөр хийлгэх явдлыг арилгаж, бүх хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр, түүний дотор хүүхдийг цэрэг болгон элсүүлэх, ашиглах явдлыг 2025 он гэхэд эцэс болгох”-д чиглэсэн.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хянаж, цаашдын бодлого, хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай статистик тоо мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу бий болгох ажлыг Үндэстний Статистикийн хороо нь хуулиар хүлээж, уг үүргийнхээ дагуу Хүүхдийн хөдөлмөрийн судалгааг 2021-2022 онд зохион байгууллаа.

Энэхүү судалгааны үр дүн нь хүүхдийн хөдөлмөр, аюултай ажил эрхэлж буй хүүхдийг тодорхойлон улмаар хүүхдийн хөдөлмөрийг хориглох, устгахад чиглэсэн бодлогын дүн шинжилгээний суурь мэдээлэл болж, судалгаа нотолгоонд суурилсан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлд бодитой дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Энэ удаагийн Хүүхдийн хөдөлмөрийн судалгааг олон улсын аргачлалаар үндэстний хэмжээнд явуулахад санхүү, техникийн туслалцаа үзүүлсэн Олон Улсын хөдөлмөрийн байгууллага болон Америкийн нэгдсэн улсын Хөдөлмөрийн яаманд талархаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд судалгааг зохион байгуулахад мэргэжлийн зөвлөгөө өгч, төслийн ажлыг хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулж, хамтран ажилласан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Судалгаа, үнэлгээний нэгжийн дарга Микаелле Де Кок, Судалгаа, үнэлгээний нэгжийн Судалгааны багийн Бодлогын судалгааны ажилтан Габриелла Бреглиа, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Монгол Улсын үндэстний зохицуулагч П.Болормаа нарт гүн талархал илэрхийлье.


Мөн судалгааны тайлан боловсруулахад арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажилласан Үндэстний статистикийн хорооны Даргын зөвлөлийн гишүүд болон Арга зүйн байнгын зөвлөлийн гишүүд, судалгааг гардан зохион байгуулсан Нийгмийн статистикийн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн Ажиллах хүчний судалгааны баг, төв, орон нутгийн статистикийн нэгжийн албан хаагчдад талархал илэрхийлье.

Судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн ажилдаа ашиглана гэдэгт итгэж байна. Та бүгдэд ажлын өндөр амжилт хүсье.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА



Б.БАТДАВАА



ХУРААНГУЙ



1.1. Удиртгал

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа”-г 2002-2003, 2006-2007, 2011-2012 онуудад “Ажиллах хүчний судалгаа”-ны модуль хэлбэрээр, олон улсын аргачлалын дагуу зохион байгуулж, үр дүнг тархааж байв. Эдгээр судалгаануудын үр дүнд, хүүхдийн хөдөлмөр, аюултай ажилд оролцуулахыг устгахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулахын тулд хүүхдийн хөдөлмөрийн статистикийн мэдээллийг тодорхой давтамжтайгаар баяжуулан, бий болгох шаардлагатай байгаа нь тогтоосон. Энэ хүрээнд Үндэсний статистикийн хороо нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан хэлтэс (FUNDAMENTALS) болон Америкийн нэгдсэн улсын Хөдөлмөрийн департаментын санхүү, техникийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа”-г 2018 онд батлагдсан шинэ аргачлалын дагуу 2021-2022 онд анх удаа бие даасан хэлбэрээр зохион байгууллаа.

1.2. Судалгааны зорилго

Судалгааны гол зорилго нь хүүхдийн хөдөлмөрийн хамрах хүрээ, төлөв байдлын талаар олон улсын шинэ стандартын дагуу тоон мэдээллийг бий болгох, статистикийн мэдээллийн санг баяжуулах, бодлого боловсруулагчдыг хүүхдийн хөдөлмөрийг устгах бодлого, арга хэмжээг боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангахад чиглэсэн.

1.3. Судалгааны товч дүн

5-17 насны хүүхэд

- ▶ Судалгаагаар Монгол Улсад 5-17 насны 852.4 мянган хүүхэд байгаагийн 436.6 мянга (51.2%) нь хөвгүүд, 415.8 мянга (48.8%) нь охид байна.
- ▶ Насны бүлгийн хувьд, 69.1 хувь нь 5-12 настай, 14.7 хувь нь 13-14 настай, 16.2 хувь нь 15-17 настай хүүхдүүд байна. Байршлын хувьд, 5-17 насны нийт хүүхдийн 69.5 хувь нь хот, суурин газарт, 30.5 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа

- ▶ Хүүхдийн ажил эрхлэлт гэж 5-17 насны хүүхдийн оролцсон бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх аливаа үйл ажиллагааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, хүүхдийг ҮТС-ийн үйлдвэрлэлийн ерөнхий хүрээн дэх¹ үйл ажиллагаа буюу эдийн засгийн үйл ажиллагаа, цалин, хөлсгүй өрхийн үйлчилгээ (эсвэл гэрийн ажил)-нд оролцуулж байгаа талаарх өргөн хүрээний ойлголт юм.
- ▶ Хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаанд татан оролцуулах гэдэг нь ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээн дэх үйл ажиллагаанд оролцохыг хэлнэ. Үүнд цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөрт оролцох ажил, өөрийн эцсийн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ажил болон цалин, хөлсгүй дадлагажих ажил орно.

1 Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн талаарх ОУХС-ийн 18 дугаар бага хурлын 4 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоол, ОУХС-ын 20 дугаар бага хурал, ОУХБ, Женев хот, 2018 он.

- ▶ Судалгаагаар улсын хэмжээнд 5-17 насны нийт хүүхдийн 208.0 мянга (24.4%) нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байна. Тэдний 60.7 хувь нь хөвгүүд, 39.3 хувь нь охид байна. Харин байршлын хувьд ялгаатай байдал ажиглагдахгүй байна (хотод 50.8%, хөдөөд 49.2%).
- ▶ Хүүхдийн нас нэмэгдэх тусам тэдний эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэж байна. Энэ хандлага байршлын хувьд хадгалагдаж байна.

Хүүхдийн хөдөлмөр

- ▶ Хүүхдийн хөдөлмөр гэж хуулиар тогтоосон хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарт хүрээгүй хүүхдийн хийж буй ажил, эсвэл гүйцэтгэж буй ажил нь хүүхдэд бие махбодын болоод сэтгэл зүйн гэмтэл учруулж тэдний эрүүл мэнд, өсөлт, хөгжилд сөргөөр нөлөөлөх ажлыг хэлнэ. Үүнд:
 - ▶ эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хөнгөн ажил хийж болохуйц наснаас доош буюу 5-12 настай хүүхэд,
 - ▶ аюултайд тооцогдоогүй ч хөнгөн бус ажил эрхэлж буй 13-14 насны хүүхэд,
 - ▶ аюултай ажил хийж буй хүүхдээр тодорхойлдог.
- ▶ Судалгаагаар улсын хэмжээнд 5-17 насны хүүхдийн 138.5 мянга буюу 16.3 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцсон байна.
- ▶ Хөвгүүд охидоос илүү хүүхдийн хөдөлмөрт оролцох хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, хөвгүүдийн хувьд хүүхдийн хөдөлмөр түвшин 19.9 хувь, охидынх 12.5 хувь байна.
- ▶ Хүүхдийн хөдөлмөрийн түвшнийг насны бүлгээр авч үзэхэд, 5-12 насны хүүхдүүдийн 16.8 хувь нь, 13-14 насныхны 12.7 хувь, 15-17 насныхны 17.0 хувь хүүхдийн хөдөлмөрт оролцож байна.
- ▶ Байршлын хувьд, хот суурин газарт амьдардаг 5-17 насны хүүхдийн 10.2 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцсон бол хөдөөд энэ үзүүлэлт 30.0 хувьтай байна.
- ▶ Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн 58.2 мянга (42.0%) нь аюултай ажил хийж байгаа бол 78.2 мянга (56.5%) нь хөнгөн ажлыг хийж болохуйц наснаас доош буюу 5-12 насны, 2.1 мянга (1.5%) нь аюултайд тооцогдоогүй ч хөнгөн бус хөдөлмөрт оролцож буй 13-14 насны хүүхэд байна.
- ▶ Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн 133.2 мянга (96.2%) нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил хийсэн, мөн 11.6 мянга (8.4%) нь цалин хөлс, орлого олох зорилготой ажил хийсэн, 212 (0.2%) нь цалин хөлсгүй дадлагажих ажил хийсэн байна.
- ▶ ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнд “өрхийн хэрэглээнд зориулж байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөх, түлээ бэлтгэх үйл ажиллагаа” нь хүүхдийн хөдөлмөрт тооцогддог гэдгийг онцлох нь зүйтэй. Иймд уг ажилд хэт олон цагаар оролцох эсвэл хөнгөн ажлыг хийж болохуйц наснаас доош насны хүүхэд оролцохыг хүүхдийн хөдөлмөрт тооцдог. Хүүхдийн хөдөлмөрт оролцсон 5-17 насны арван хүүхэд тутмын тав нь уг үйл ажиллагаанд, мөн гурав нь мал аж ахуй эрхлэх, нэг нь газар тариалан эрхлэх үйл ажиллагаанд оролцсон байна. Манай орны эдийн засагт мал аж ахуйн салбар багагүй хувийг эзэлдэг бөгөөд малчин өрхийн хүүхдүүд багаасаа мал аж ахуйн ажилд идэвхтэй оролцож гэр бүлдээ тусалдаг нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо өндөр гарахад нөлөөлдөг.
- ▶ Улсын хэмжээнд 5-17 насны хүүхэд долоо хоногт дунджаар 8 цаг (бүх ажлын хэлбэрүүдийн нийт цаг) хүүхдийн хөдөлмөрт оролцож байна, үүнээс хөвгүүд 8 цаг, охид 7 цаг зарцуулсан байна. Байршлын хувьд хот, суурин газарт амьдарч буй хүүхэд 5 цаг, хөдөө амьдарч буй хүүхэд 10 цаг зарцуулсан байна. Харин зөвхөн цалин хөлс, орлого олох ажилд долоо хоногт дунджаар 19 цаг, өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажилд 7 цаг зарцуулсан байна.

- ▶ Хүүхдийн хөдөлмөрийн түвшин улирлаар харилцан адилгүй байна. Тухайлбал хүүхдийн хөдөлмөр 1-ээс 3-р улиралд аажмаар өсөж 18.6 хувьд хүрч (хамгийн өндөр), 4 дүгээр улиралд буурч 10.6 хувь (хамгийн бага)-д хүрсэн байна. Манай орон эрс тэс уур амьсгалтай, 4 дүгээр улиралд гадаа ажиллахад тохиромжгүй хамгийн хүйтэн, хатуу ширүүн уур амьсгалтай улирал учраас хүүхдүүд тус улиралд хүүхдийн хөдөлмөрт оролцох нь бага байх талтай юм. Харин 3 дугаар улиралд хүүхдийн хөдөлмөр хамгийн их байгаа нь тухайн улиралд эдийн засгийн ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх хамгийн боломжтой дулаан уур амьсгалтай байдаг, малчид, газар тариаланчдын хувьд намар, өвлийн улиралд бэлтгэх олон төрлийн ажил хийгддэг, түүнчлэн сургуулийн зуны амралтын цаг үе таардагтай холбоотой.

Аюултай ажил

- ▶ Аюултай ажлыг хүүхдийн оролцож байгаа ажлын шинж чанар, ажлын орчин, нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөөтэй байгаа эсэхээр тодорхойлогдоно. Үүнд:
 - ▶ Хуульд зааснаар “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байр”-нд ажиллах;
 - ▶ Хүүхдийн аюулгүй байдалд хор нөлөө үзүүлэх ажлын нөхцөлд ажиллах;
 - ▶ Хэт их цагаар ажиллах. Өөрөөр хэлбэл, ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний бүхий л үйл ажиллагаанд 7 хоногт 30-аас их цаг зарцуулж байгаагаар тодорхойлно.
- ▶ Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 58.2 мянга нь аюултай ажил хийж, тухайн насны хүүхдийн аюултай ажилд оролцсон оролцооны түвшин 6.8 хувь байна.
- ▶ Аюултай ажил хийж буй 58.2 мянган хүүхдийн 68.2 хувь нь хөвгүүд, 68.5 хувь нь хөдөө амьдардаг хүүхдүүд байгаа нь хүйс, байршлын хувьд ихээхэн ялгаатай байгааг харуулж байна.
- ▶ Аюултай ажил хийж буй 5-17 насны нийт хүүхдийн 4.8 мянга (8.2%) нь “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-д тусгагдсан хориотой ажлын байранд ажиллаж байна. Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байранд ажиллаж буй арван хүүхэд тутмын дөрөв нь барилгын салбарт дотоод засал, чимэглэлийн ажил, барилгын материал, багаж хэрэгсэл зөөх зэрэг барилгын туслан гүйцэтгэх ажлыг хийж байна.

Хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхдүүдийн 4.7 мянга (3.4%) нь долоо хоногт 30-аас их цагаар буюу хэт их цагаар ажилласан байна.


Ажлын байрны нөхцөлийн хувьд, хүүхдийн хөдөлмөрт оролцож буй 5-17 насны хүүхдийн ихэнх нь хэт өндөр температур эсвэл чийгшил, тоос шороотой нөхцөл (27.5%)-д ажилласан байна. Хүйсийн хувьд хөвгүүд, байршлын хувьд хөдөө амьдарч буй хүүхдүүд эрүүл мэнд, аюулгүй байдал бүрэн хангагдаагүй орчин, нөхцөлд ажиллах эрсдэл өндөр байна.

Хүүхдийн гэр бүл, өрхийн нийгэм, эдийн засгийн байдал

- ▶ Судалгаагаар эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 14.1 хувь нь, эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийн 16.8 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцсон байна. Хүүхэд гэр бүлтэйгээ хамт амьдардаг эсэхээс хамаараад хүүхдийн хөдөлмөрийн түвшин бага зэргийн ялгаа ажиглагддаг. Хүүхдийн хөдөлмөрийн түвшнийг ам бүлийн тоогоор нь авч үзэхэд, хамгийн өндөр нь 7-8 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдүүдийнх 21.4 хувь, хамгийн бага нь 3-4 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийнх 12.7 хувь байна.

- ▶ Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин буурах тусам хүүхдийн хөдөлмөрийн түвшин өссөн байна. Тухайлбал, өрхийн тэргүүлэгч нь дээд боловсролтой өрхийн дунд хүүхдийн хөдөлмөр 10.2%, өрхийн тэргүүлэгч нь боловсролгүй болон бага боловсролтой өрхийн хувьд 30.6-33.2 хувьд хүрч нэмэгдэж байна.
- ▶ Төвлөрсөн усан хангамжтай өрхийн хүүхдүүд хүүхдийн хөдөлмөрт оролцох нь бага (1.4%), булгийн усаар хангадаг өрхөд хамгийн их (49.4%) байгаа нь хүүхдийн хөдөлмөр, өрхийн усан хангамж хоёрын хооронд тодорхой уялдаа байгааг харуулж байна.
- ▶ Мөн өрхийн сууцны төрлөөр, орон сууцны байшинд эсвэл бие даасан тохилог сууцанд амьдардаг өрхийн хүүхдүүдийн 1.3-2.0 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцож байгаа бол гэрт амьдардаг хүүхдүүд (25.2%) болон зориулалтын бус сууцанд амьдардаг хүүхдүүд (29.9%) хүүхдийн хөдөлмөрт оролцох нь их байна.
- ▶ Хүүхдийн хөдөлмөрийн тархалт сард 200.0-400.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн хувьд 28.0% нь байхад 1400.0 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхийн хүүхдийнх 9.1 хувь болж буурч байна.
- ▶ Орлого нь буурсан өрхийн хүүхдүүд хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлал нь өндөр байна: Хүүхдийн хөдөлмөр ямар нэг хямралд өртөөгүй өрхүүдэд 15.9%, байгалийн хүчин зүйлээс шалтгаалан хямралд өрсөн өрхүүдэд 23.4%, эдийн засгийн хямралд өртсөн өрхүүдэд 21.0%, гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь өвдсөн өрхийн хувьд 12.1% байна.





2

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



2.1. Эрх зүйн баримт бичиг

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг устгах хүчин чармайлтыг уриалж, 2021 оныг Хүүхдийн хөдөлмөрийг устгах жил болгон зарлаж байсан. Хүүхдийн хөдөлмөр нь олон улсын конвенц, тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай конвенц, ОУХБ-ын 138, 182 дугаар конвенциудаас үүдэлтэй эрх зүйн ойлголт юм. Түүнчлэн, хүүхдийн хөдөлмөрийн статистикийн тухай тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 18 дугаар бага хурлын тогтоол нь хүүхдийн хөдөлмөрийг хэмжих лавлагаа баримт бичиг болдог. Эдгээр эрх зүйн болон хэмжилтийн стандартуудыг дараах дэд бүлгүүдэд тусгалаа.

1. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (1989 он, ХЭК)

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдийн эдлэх эрхүүдийг тунхагласан олон улсын эрх зүйн баримт бичиг бөгөөд уг конвенцод 18 нас хүрээгүй хүн бүрийг “хүүхэд” гэж тодорхойлдог. Тус конвенцын тогтоосон олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүүхэд бүр ямар ч алагчлалгүйгээр хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ хүртэж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж, бие хүн болж төлөвших, авьяас, чадвараа бүрэн дүүрэн нээн хөгжүүлэх боломжоор хангагдаж, аз жаргал, хайр энэрэл, ойлголцол бүрдсэн орчинд өсөн торниж, эрхээ эдлэх үйл явцдаа идэвхтэй оролцох боломжоор хангагдах зэрэг нөхцөлийг бүрдүүлэх үүргийг конвенцын гишүүн орнууд хүлээсэн.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод, 2003 онд Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Нэмэлт протоколд, 2004 онд Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Нэмэлт протоколд нэгдэн орсон. Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хуульд “Монгол Улсын иргэнийг төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 нас хүртэл хүүхэд” гэж тооцон хамааруулахаар зохицуулж, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх заалтад “хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заажээ.

2. Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын конвенц (1973 он, №.138)

Энэ конвенцоор хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 15 нас (хөнгөн ажил бол 12 нас), мөн ажлын нөхцөл, шинж чанараасаа хамаараад хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд аюул учруулахуйц, аюултай хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 18 нас (аюултай ажил) гэж тогтоосон байдаг. Мөн хөдөлмөрийн насны доод хязгаарыг заавал сургууль дүүргэх наснаас багагүй байхаар заасан. Гэсэн хэдий ч тухайн улсын эдийн засаг, боловсролын тогтолцоо нь доогуур түвшинд байгаа бол хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 14 (хөнгөн ажил бол 12) байж болохыг заажээ. Мөн конвенцод хөнгөн хөдөлмөрийг (i) хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй, (ii) хичээлдээ суух, эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн чиг олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрагдах болон олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй байх (Зүйл.7) зэрэг шаардлагыг хангасан байх ёстойг тусгасан.

Монгол Улс нь 2002 онд “Насны доод хязгаарын тухай” 138 дугаар конвенцод нэгдсэн орсон бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн аравдугаар бүлэгт хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль эрх зүйн суурь зохицуулалтыг заасан байна. Тухайлбал,

- ▶ 142 дугаар зүйлийн 142.1 дэх хэсэгт 15 насанд хүрээгүй хүнээр энэ хуулийн 142.3, 142.5²-д зааснаас бусад тохиолдолд хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно”,
- ▶ 142 дугаар зүйлийн 142.3-т “Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхгүй, сурч боловсроход саад учруулахгүй нөхцөлд 13-15 насны хүнийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх,

2 15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаар хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн бичгээр гаргасан зөвшөөрөл, ажиллах цаг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг үндэслэн хүүхдийн эрхийн улсын байцаагч тухай бүр зөвшөөрөл олгосон бол хөдөлмөр эрхлүүлж болно.

асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд хөнгөн ажил эрхлүүлж болно”,

- ▶ 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт “Насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30-аас илүүгүй байна” гэж заасан.

3. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенц (1999, №.182)

Энэхүү конвенцод нэгдэн орсон улсууд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг, тухайлбал, боолчлолын бүх хэлбэрүүд, боолчлолтой ижил төстэй үйл ажиллагаа, хүүхдийг худалдаалах, наймаалах, өрийн төлөөс болгох, хамжлага байдлаар ашиглах, хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд татан оролцуулах, хүүхдийн биеийг үнэлүүлэн бэлгийн мөлжлөгт өртүүлэх, садар самуунд ашиглах, хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд, ялангуяа мансууруулах бодис үйлдвэрлэх, худалдаалахад ашиглах, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, бүрэн устгахад чиглэсэн арга хэмжээг авах үүрэг хүлээнэ. Түүнчлэн, конвенцод нэгдэн орсон улс хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрүүлэх, өртсөн тохиолдолд нөхөн сэргээж, нийгмийн амьдралд дасаж, нийгмийн харилцаанд ороход нь тохиромжтой, шаардлагатай дэмжлэгийг шууд үзүүлэх үүрэгтэй.

ОУХБ-ын 1999 оны “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн 190 дүгээр зөвлөмж”-д аюултай ажлыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- А) Хүүхдийг бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэлд өртүүлж болзошгүй ажил,
- Б) Газрын гүнд, усан доор, хэт өндөр, эсвэл хэт давчуу орон зайд явагдах ажил,
- В) Аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах, түүнийг гараар удирдах буюу хүнд ачаа тээвэрлэх ажлууд,
- Г) Аюултай химийн бодис хэрэгсэл, үйл ажиллагаа буюу эрүүл мэндэд хохирол учруулахуйц температур, дуу чимээний түвшин, чичрэлт доргилт зэрэг эрүүл бус орчинд ажиллах ажлууд,
- Д) Уртасгасан цагаар, эсвэл шөнийн ээлжид ажиллах, ажил олгогчийн байранд тодорхой шалтгаангүйгээр байрлуулж ажиллуулах.

Монгол Улс нь 2001 онд “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай” 182 дугаар конвенцыг соёрхон баталсан бөгөөд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг 2011 онд баталсан. Мөн Эрүүгийн тухай хуульд хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэхийг гэмт хэрэгт тооцож, тус хуулийн 16.10.1-д хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн бол хүлээлгэх хариуцлагыг зааж өгсөн.

2023 оны 6 сарын 1-ний өдрийн байдлаар Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцод дэлхийн 176 улс, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенцод 187 улс нэгдэн орсон байна.

4. Олон улсын хөдөлмөрийн статистикчдын бага хурлын тогтоол

Олон улсын хөдөлмөрийн статистикчид /ОУХС/-ын бага хурлаар хөдөлмөрийн статистикийн олон улсын стандартыг тогтоодог бөгөөд олон улсад 2013 он хүртэл 1982 оны ОУХС-ын 13-р бага хурлын тогтоолоор, 2014 оноос 2013 онд болсон 19-р бага хурлын “Ажил, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн дутуу ашиглалт” тогтоол бүхий олон улсын статистикийн стандарт арга зүйн баримт бичгийг мөрдлөг болгож байна.

Харин Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн аргачлалын хувьд 2008 он хүртэл ОУХС-ын 13-р бага хурлын тогтоолын дагуу насанд хүрсэн хүний хөдөлмөр эрхлэлттэй адил авч үзэж байсан бол 2018 оны ОУХС-ын 18-р бага хурлаар хүүхдийн хөдөлмөрийг насанд хүрсэн хүний хөдөлмөр эрхлэлтийн ойлголт, аргачлалаас тусад нь авч үзэх хэрэгтэйг онцлон тэмдэглэж, “Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн тухай” анхны бие даасан тогтоолыг гаргасан. Үүний дараа ОУХС-ын

19-р бага хурлын тогтоолоор ажил, хөдөлмөрийн ойлголт шинэчлэгдсэн тул 2018 онд болсон 20-р бага хурлаар Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн аргачлалыг шинэчлэн баталсан.


Өнөөгийн байдлаар хөдөлмөрийн статистикийн ойлголт, аргачлалд ОУХС-ын 19, 20-р бага хурлын тогтоол, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн 21 улс, хэсэгчлэн хэрэгжүүлсэн 15 улс байгаа ба Монгол Улс 2019 оноос эхлэн бүрэн хэрэгжүүлж эхлээд байна.

2.2. Статистикийн ойлголт, тооцооллууд

Судалгааны асуулгын хуудсыг боловсруулах, үр дүнг тооцоход Үндэсний статистикийн хорооны дарга болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг ашигласан. Энэхүү аргачлалыг 2013, 2018 онуудад болсон ОУХС-ын 19, 20-р бага хурлуудын тогтоол, зөвлөмжийн дагуу боловсруулсан.

Хүүхдийн ажлын талаарх өргөн хүрээний ойлголт нь Үндэсний тооцооны систем 2008 (ҮТС)-д тодорхойлсон үйлдвэрлэлийн ерөнхий хүрээний аливаа үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхэд юм. Судалгаагаар ОУХС-ын 2013 оны 19 дүгээр бага хурлын тогтоолоор тодорхойлсон ажлын хэлбэрүүдийн буюу Зураг 2.1-т харуулсан ажлын хэлбэрүүдээс өөрийн эцсийн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа, цалин хөлс, орлого олох зорилготойгоор бусдад зориулж хийж байгаа үйл ажиллагаа, цалин хөлсгүй дадлагажих үйл ажиллагааны мэдээллийг цуглуулсан. Харин сайн дурын ажлын хэлбэрийг хамруулаагүй. Энэхүү тайлан нь Үндэсний тооцооны систем (ҮТС)-д тодорхойлсон үйлдвэрлэлийн хүрээнд тайлагнасан.

► Зураг 2.1. Ажил, түүний хэлбэр



Тайлбар: G – Үйлдвэрлэл
S – Үйлчилгээ

►Зураг 2.2. Хүүхдийн хөдөлмөр, ажлын хэлбэрээр



Энэхүү тайлангийн зорилгын хүрээнд **хүүхдийн хөдөлмөр** гэдэгт лавлагаа хугацаанд дараах төрлийн нэг буюу хэд хэдэн үйл ажиллагаанд оролцож байгаа 5-17 насны хүүхдийг хамруулна. Үүнд:

- А. ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний аюултай ажил эрхэлж буй хүүхэд;
- Б. ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажил эрхэлж буй хөдөлмөр эрхлэх насны доод хязгаараас доош (5-12 нас) насны хүүхэд;
- В. ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний хөнгөн бус ажил эрхэлж буй хөдөлмөр эрхлэх насны доод хязгаараас доош (13-14 нас) насны хүүхэд.

Судалгаагаар хүүхдийн оролцож буй бүх үйл ажиллагааны мэдээллийг ҮТС-ийн үйлдвэрлэлийн

ерөнхий хүрээнд цуглуулсан. Гэхдээ хүүхдийн хөдөлмөрийг ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний үйл ажиллагаагаар хэмжиж, хүүхдийн оролцож буй өрхийн өөрийн үйлчилгээний аюултай ажлыг тусад нь тооцож, тайланд тусгав. Иймд үйлдвэрлэлийн ерөнхий хүрээний цалин хөлсгүй өрхийн үйлчилгээний аюултай ажил эрхэлж буй хүүхдийг хүүхдийн хөдөлмөрийн хөдөлмөрт тооцоогүй.

▶ Хүснэгт 2.1. Хүүхдийн хөдөлмөрийн статистик үзүүлэлтийг тодорхойлох арга зүйн хүрээ

Насны бүлэг	Үйлдвэрлэлийн ерөнхий хүрээ				(3a) Өрхийн цалин хөлсгүй аюултай үйлчилгээ ⁴	(3b) ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнд гадуурх бусад ажил
	ҮТС-ийн үйлдвэрлэл			Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд		
	(1a) ҮТС-ийн үйлдвэрлэл-ийн хүрээний хөнгөн ажил ³	(1b) ҮТС-ийн үйлдвэрлэл-ийн хүрээний ердийн ажил ²	(2a) ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний аюултай ажил ²			
Хөнгөн ажил хийх насанд хүрээгүй хүүхэд (5-12 настай) ⁵	Хөнгөн ажил хийх насанд хүрээгүй хүүхдийн ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажил	Хөдөлмөр эрхлэх насанд хүрээгүй хүүхдийн ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний ажил	Аюулттай салбар, мэргэжлээр ажиллаж байгаа эсвэл хэт их цагаар ажиллаж байгаа хүүхэд	(2b) Аюултай ажлаас бусад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд	Өөрийн эцсийн хэрэглээний үйлчилгээ эсвэл өрхийн үйлчилгээний ажлыг сайн дураар олон цагаар хийх, аюултай орчин, аюултай тоног төхөөрөмж ашиглах, хэт ачаалалтай ажиллах гэх мэт.	
Хөнгөн ажил хийх боломжтой насны хүүхэд (13-14 настай) ⁴						
Хөдөлмөр эрхлэх насанд хүрсэн буюу хөдөлмөрийн насны доод хязгаарт хүрсэн хүүхэд (15-17 настай) ⁴						

Тайлбар:

- Энэхүү тайланд хүүхдийн хөдөлмөрийн ойлголтын хэмжсэн хүрээ
- Хүүхдийн хөдөлмөрт тооцогдохгүй үйл ажиллагааны хүрээ

3 ОУХС-ын 19-р бага хурлаар (2013) батлагдсан “Ажил, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалтын тухай тогтоол”-той уялдуулан ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлт, өөрийн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, цалин хөлсгүй дадлагын ажил, зах зээлийн болон зах зээлийн бус нэгжийн сайн дурын ажил, өрхийн үйлдвэрлэлийн сайн дурын ажил зэрэг ажлын хэлбэрүүд орно.

4 (3a) гэсэн категори хүүхдийн хөдөлмөрийг ҮТС-ийн үйлдвэрлэлийн ерөнхий хүрээнд хамруулан судалж байгаа тохиолдолд ашиглана. Судалгаагаар нийт хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тоонд цалин хөлсгүй аюултай ахуйн үйлчилгээ эрхэлж буй хүүхдийн тоог оруулаагүй, хассан болно.

5 Насны бүлэг нь тухайн улс орны нөхцөл байдлаас хамаарч янз бүр байж болно.

Аюултай ажлыг хүүхдийн эрхэлж байгаа ажлын шинж чанар, уг ажлыг хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлын нөхцөлд гүйцэтгэж байгаа эсэхээр тодорхойлно. Үүнд:

- ▶ Аюултай ажил мэргэжил, үйл ажиллагаа, хуулиар хориглосон болон насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байранд ажиллах. Судалгаанд дараах ангиллуудыг ашигласан. Үүнд:
 - ▶ Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн А/183 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын боловсролын түвшний ангилал”,
 - ▶ Монгол Улсын сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 319, А/160 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”,
 - ▶ Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2010 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал ба Тодорхойлолт YAMAT-08 (ISCO - 08)”,
 - ▶ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код (MNS-5641-1:2006:).
- ▶ Хүүхдийн аюулгүй байдалд хохирол учруулах нөхцөлд ажиллах. Үүнд:
 - ▶ Аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж зэвсэг, химийн бодистой харьцах, хүнд ачаа гараараа өргөж зөөх болон тээвэрлэх, том мал, амьтантай харьцах, их халуун, хүйтэн, харанхуй, үзэгдэх орчин муу, газар доор, усны гүнд, аюултай өндөрт эсвэл дуу чимээ ихтэй, тоос шороо, утаатай, хэтэрхий давчуу орон зайд ажиллах,
 - ▶ Хүнд ачаа өргөх, зөөх. Энэ нөхцөлийг “Насанд хүрсэн хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-д тусгагдсан “Насанд хүрээгүй хүний гараар өргөх, зөөх ачааны массын зөвшөөрөгдөх дээд хэмжээний дагуу тооцсон.
 - ▶ Хэт их цагаар ажиллаж буй хүүхдийг ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний бүхий л үйл ажиллагаанд зарцуулсан нийт цаг нь хуулиар тогтоосон дээд хэмжээ (7 хоногт 30 цаг)-нээс их байх нөхцөлөөр тодорхойлсон. Ингэхдээ долоо хоногт зарцуулсан жинхэнэ ажлын цагаар тооцсон.
 - ▶ Харин өөрийн эцсийн хэрэглээний үйлчилгээний аюултай ажил (эдийн засгийн бус үйл ажиллагаа) гэж 5-14 хүүхэд 7 хоногт 21 болон түүнээс дээш цагаар өрхийн болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаагаар тооцсон.

Хөнгөн ажлыг тодорхойлохдоо 13-14 насны хүүхдийн ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнд эрхэлж байгаа бүхий л ажлын нийт цаг долоо хоногт 14 цагаас бага байхаар тооцсон.

2.3. Судалгааны түүвэрлэлт

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж нь өрх байна. Өрх гэж нэг орон байранд хамт амьдардаг нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг, хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ.

Дараах өрх, хүн амыг судалгаанд хамруулсан. Үүнд, өрхийн гишүүн биш, өрхийн ам бүлд бүртгэлгүй ч тухайн өрхөд судалгааны хугацаанд амьдарч байгаа хүн. Жишээ нь, тухайн өрхийн цалинтай малчин, хүүхэд асрагч гэх мэт.

Дараах өрх, хүн амыг судалгаанд хамруулаагүй. Үүнд:

- ▶ 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар өрхөөс гадуур байгаа болон мөн хугацаагаар өрхөөс гадуур байхаар явсан гишүүд,
- ▶ Хорих газарт хоригдож байгаа хүмүүс,
- ▶ Халамжийн төвүүд, асрах газарт амьдарч байгаа хүмүүс,
- ▶ Хугацаат цэргийн албан хаагчид.

Өрхөд суурилсан судалгаа тул тухайн өрхийн 5-17 насны хүүхдүүд судалгаанд хамрагдах ба гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүд болон засан хүмүүжүүлэх газар, асрах газар, халамжийн төв зэрэг нийтийн байранд амьдарч буй хүүхдүүд хамрагдаагүй. Судалгааны хамрах хүрээ нь Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн 5-17 насны хүүхэдтэй өрх байна. Судалгааны түүврийн хүрээг ХАӨМС-гийн 2020 оны жилийн эцсийн мэдээлэлд үндэслэн бэлтгэсэн. Манай улсад 2020 оны эцэст 5-17 насны 816.7 мянган хүүхэд 475.0 мянган өрхөд амьдарч, 5-17 настай хүүхэд нийт хүн амын 25.1 хувийг эзэлж байсан бол 5-17 насны хүүхэдтэй өрх нийт өрхийн 52.3 хувийг эзэлж байв.

Судалгаанд хамрагдсан 13144 өрхөөс авсан мэдээлэл нь Монгол Улсын нийт өрхүүдийг төлөөлөхдөө судалгааны асуулгаар цуглуулсан мэдээллийн бодит байдал үндэсний хэмжээнд 5 хувиас хэтрэхгүй алдааны магадлалтай ба түүвэрлэлтийн загварын нөлөөний утга нь 1.5-аас хэтрэхгүй байхаар хийгдсэн болно.

2.4. Судалгааны асуулгын хуудас, мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн талаарх ОУХС-ийн 18 дугаар бага хурлын тогтоолыг шинэчлэн, өөрчлөх тухай 2018 оны ОУХС-ын 20 дугаар бага хурлын тогтоолын дагуу ОУХБ-аас “Мэдээлэл цуглуулах маягт боловсруулах” ажлын хэсэг байгуулагдан, ажилласан. Иймд Монгол Улс ОУХБ-ын ХХС-ны уг асуулгыг өөрийн орны онцлогт нийцүүлэн боловсруулсан. Мөн Үндэсний статистикийн хороо нь “Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны маягтын төсөл болон үр дүнгийн тайлангийн төсөлд санал өгөх” үүрэг чиглэл бүхий салбар дундын техникийн ажлын хэсэг байгуулан ажилласан.

Маягтын төслийг боловсруулах явцад, танин мэдэхүйн тест болон туршилтын судалгааг зохион байгуулж, ҮСХ-ны Арга зүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, баталсан.

ХХС-ны асуулгын маягт нь өрхийн хаягийн хэсэг, ам бүлийн байдал, эрүүл мэнд, шилжих хөдөлгөөн, боловсрол, эдийн засгийн үйл ажиллагаа, аюултай ажил, ажлын байрны нөхцөл, эдийн засгийн бус үйл ажиллагаа бүхий 9 бүлгийн 266 асуултаас бүрдсэн.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 10 сард эхлэн 2022 оны 9 сарыг дуустал буюу 12 сарын мэдээллийг цуглуулсан. Мэдээлэл цуглуулалтын ажлыг нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн өрхөд суурилсан судалгааны мэдээлэл цуглуулах багийн ахлагч, судлаач нар хийж гүйцэтгэсэн. Судлаач нь тухайн сард сонгогдсон өрхөд очиж өрхөд амьдарч байгаа 5-17 насны гишүүнийг судалгаанд хамруулсан. Ингэхдээ 5-11 насны хүүхэд асуултыг ойлгохгүй байх магадлалтай тул тухайн хүүхдийн талаар бүрэн мэдээлэл өгч чадах өрхийн насанд хүрсэн гишүүнийг байлцуулан, 12-17 насны хүүхдээс өөрөөс нь асууж, ярилцлага хийх замаар мэдээллээ таблет ашиглан нүүр тулсан ярилцлага авч (CAPI) цуглуулсан. Харин 12-17 насны хүүхэд өөрөө мэдээлэл өгөх боломжгүй тохиолдолд тухайн хүүхдийн талаар бүрэн мэдээлэл өгч чадах өрхийн насанд хүрсэн гишүүнийг байлцуулан ярилцлага хийсэн.


Судалгааны мэдээлэл цуглуулах явцад дараах зарчмыг баримталж ажилласан. Үүнд:

- ▶ Судалгааны явцад ОУХБ-тай хамтран судалгааны мэдээлэл цуглуулах багт 7 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан,

- ▶ Судалгааны мэдээллийн чанарт хяналт хийх, тулгарч буй асуудлуудад заавар зөвлөмж өгөх үүднээс ҮСХ-ны судалгаа хариуцсан албан хаагчид Улаанбаатар хот болон аймаг, орон нутгийн судалгааны мэдээлэл цуглуулах багтай хамтран судалгаанд хамрагдсан, тухайн хугацаанд хамрагдаж байгаа өрхөд очин хамтран ажилласан.

Судалгааны мэдээллийн баазыг үүсгэх, шалгахад CSPRO багц программыг, мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулах, холбогдох хүснэгтүүдийг тооцож гаргахад SPSS, STATA программ хангамжийг ашигласан.





3

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ




3.1. Хүн ам


Монгол Улсын хүн ам 2022 онд 3.5 сая болж өмнөх оноос 47.6 мянгаар буюу 1.4 хувиар өссөн байна. 2010 онд 1.8 сая хүн ам хот суурин газарт (нийт хүн амын 67.9 хувь) амьдарч байж. Харин 2022 оны байдлаар хот, суурин газарт амьдарч буй хүн ам 2.4 саяд хүрч нэмэгдсэн байна. Түүнчлэн, Улаанбаатар хотод амьдарч буй хүн амын хувь 2010 онд 64.2 байсан бол 2022 онд 69.8 болж 5.6 нэгж хувиар нэмэгджээ.

2022 оны эцэст Монгол Улсын суурин хүн амын 2.3 сая (67.5%) нь хөдөлмөрийн насны хүн ам байгаа нь өмнөх оноос 44.8 мянган хүнээр нэмэгджээ. Хэдийгээр сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны хүн ам өссөн ч бүтцийн хувьд томоохон өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Тухайлбал, ерөнхий ажиллах хүчний бүлэг болох 25-54 насны хүн амын нийт хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувийн жин 2022 онд өмнөх оноос 0.6 нэгж хувиар буурч, тэтгэвэрт гарах насныхан болон өндөр настнуудын эзлэх хувь 0.6 нэгж хувиар өссөн байна.

▶ Зураг 3.1. Хүн амын нас хүйсийн суварга



▶ Зураг 3.2. Хүн ам зүйн ачаалал, хувиар



Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах үзүүлэлт болох хүн ам зүйн ачаалал нь 15-64 насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцаагаар илэрхийлэгддэг. Манай улсын хүн ам зүйн ачаалал 2022 онд 59.7 болж өмнөх оноос 0.2 нэгж хувиар өссөнөөс 0-14 насны хүүхдийн ачаалал 52.0 болж 0.2 нэгж хувиар буурч, 65-аас дээш насны хөгшдийнх 7.7 болж 0.4 нэгж хувиар нэмэгдсэн байна.

3.2. Эдийн засгийн өсөлт, бүтцийн өөрчлөлт

Монгол Улсын эдийн засаг 2000 оноос тогтмол өсөж байсан ба 2004 оноос түүхий эдийн үнэ өсөж, хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр ГШХО-ыг нээлттэй болгосноор тус онд эдийн засгийн огцом сэргэлт ажиглагдсан. Харин 2008 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр огцом буурч, 2009 онд ДНБ-ий өсөлт -1.3 хувьд хүрч байсан.

Монгол Улс 2008 оны хямралыг хохирол багатайгаар даван гарсан гэж үздэг бөгөөд энэхүү хямралын дараа дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ огцом өсөж, манай улсын экспорт нэмэгдэн, эдийн засгийн өсөлт 2011 онд хамгийн өндөр буюу 17.3 хувьд хүрсэн.

Дэлхийн санхүү, эдийн засгийн хүндрэл, уул уурхай, олборлох салбарын түүхий эдийн үнийн тасралтгүй уналт, ГШХО-ын бууралт зэргээс шалтгаалан 2012-2016 онуудад эдийн засгийн өсөлт 12.3-аас 1.5 хувь хүртэл буурсан. Эдийн засгийн өсөлт 2019 онд 5.6 хувьтай байсан бол Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд эдийн засгийн өсөлт 4.6 хувиар буурч байсан. Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт хурдан сэргэж, 2022 онд 5.0 хувиар өссөн.

►Зураг 3.3. Эдийн засгийн өсөлт, бууралт, хувиар




Манай Улсын нэг хүнд ногдох ДНБ, 2000 онд 485 ам.доллар, нэг хүнд ногдох ҮНО 448 ам.доллар байсан бол 2022 онд нэг хүнд ногдох ДНБ 5033 ам.доллар, нэг хүнд ногдох ҮНО 3953 ам.долларт хүрсэн. Хэдийгээр уг өсөлт ажиглагдаж байгаа ч 2014-2017 оны хооронд уг үзүүлэлтүүд тасралтгүй буурсан ба нэг хүнд ногдох ҮНО илүү хурдтай буурсан байна.

3.3. Ядуурлын түвшин


Эдийн засгийн сэргэлтийн үе буюу 2010-аас 2014 онд ядуурал 38.8 хувиас 21.6 хувь болж эрчимтэй буурч байсан бол эдийн засгийн хямралын улмаас 2016 онд эргээд 29.6 хувь болж өсжээ. Ядуурлын хамралтын хүрээ 2020 онд 27.8 хувь болж 2018 оноос 0.6 нэгж хувиар буурч, ойролцоогоор нийт хүн амын 903.4 мянга нь ядуу амьдарч байна. Ерөнхий дүр зургаар нь авч үзвэл, 2010-аас 2020 оны хооронд Монгол Улсын хүн амын ядуурал 11.0 нэгж хувиар буурчээ.

►Зураг 3.4. Ядуурлын хамралтын хүрээ болон ядуу хүн амын тоо, улсын дунджаар



Ядуурлын түвшнийг байршлаар авч үзэхэд, 2010-аас 2020 оны хооронд хөдөөд нэлээд ахиц гарсан нь ажиглагдаж байна. 2010 онд хөдөөгийн хүн амын арван хүн тутмын тав нь ядуу амьдарч байсан бол 2020 онд хөдөө амьдарч буй арван хүн тутмын гурав нь ядуу байна. Хот, хөдөөгийн ядуурлын хамралтын хүрээний зөрүү багассан, гэхдээ хот суурин газарт ядуу хүн амын төвлөрөл харьцангуй их байна. Хот суурин газарт амьдарч байгаа ядуу хүн амын эзлэх хувь нийт ядуу хүн амын 55.2 хувь (2010 онд) байснаа 63.9 (2020 онд) хувь болон өсжээ.

►Зураг 3.5. Ядуурлын хамралтын хүрээ, хувиар, ядуу хүн амын тоо, байршлаар



3.4. Тэгш бус байдал

Тэгш бус байдлыг Үндэсний статистикийн хороо Жини коэффициент болон Тейлийн индексээр хэмжиж байна. Жини коэффициент нь хүн амын хэрэглээний зардлын тэгш бус хуваарилалтыг илэрхийлсэн үзүүлэлт юм. Уг үзүүлэлт нь 0-1-ийн хооронд утга авах ба "0" утга руу ойртоход хүн амын хэрэглээний ялгаа багасаж, "1" утгад ойртоход хэрэглээний тэгш бус байдал өндөр байгааг илэрхийлнэ.

Хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент улсын дунджаар 2020 онд 0.32 болж 2018 оноос 0.01 нэгжээр буурсан байна. Орлогын ялгаатай бүлэг доторх болон бүлэг хоорондох тэгш бус байдлыг харуулах Тейлийн индекс 2020 онд 0.17 болж, 2018 оноос 0.02 нэгжээр буурсан байна.


►Хүснэгт 3.1. Тэгш бус байдал

Үзүүлэлт	2010	2012	2014	2016	2018	2020
Жини коэффициент	0.33	0.34	0.32	0.32	0.33	0.32
Хот	0.33	0.34	0.33	0.33	0.34	0.33
Хөдөө	0.32	0.31	0.28	0.30	0.29	0.29
Тейлийн индекс	0.19	0.20	0.19	0.19	0.19	0.17
Хот	0.19	0.21	0.20	0.20	0.21	0.19
Хөдөө	0.18	0.16	0.15	0.15	0.15	0.14

Эх үүсвэр: ӨНЭЭС 2010-2020

Тэгш бус байдлыг хэмжих өөр нэг арга бол хүн амыг хэрэглээний түвшнээр нь тэнцүү 5, 10 бүлэгт хуваах арга юм. Хүн амын хамгийн чинээлэг (V) 20 хувийн хэрэглээний дундаж хэмжээ 2020 онд хамгийн бага хэрэглээтэй (I) 20 хувийнхнаас 5.2 дахин өндөр байна.


►Зураг 3.6. Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 5 бүлгээр, дүнд эзлэх хувиар



3.5. Өрхийн амьжиргаа

Өрхийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр 2010-2014 он хүртэл тасралтгүй өсөж, мөн үеэс хойш 2016 он хүртэл буурч, 2017-2022 онд өссөн дүнтэй байна. Өрхийн орлого 2022 онд нэрлэсэн дүнгээр 1.9 сая төгрөгт хүрсэн нь 2010 оноос 1.4 сая төгрөгөөр буюу 4.1 дахин их байна. Харин үнийн нөлөөллийг арилган 2015 оны зэрэгцүүлэх үнээр илэрхийлж үзэхэд, 2022 онд өрхийн сарын дундаж бодит нийт орлого 1.2 сая төгрөг болж байгаа нь 2010 онтой харьцуулахад 62.9 хувиар, 2021 оноос 1.1 хувиар өссөн байна.

►Зураг 3.7. Өрхийн сарын дундаж бодит орлогын өсөлтийн хувь (%), (2010=100)



Өрхийн сарын дундаж бодит орлогын жилийн өсөлтийн хувь нь 1990 оноос хойших Монгол Улсын нийгэм, эдийн засгийн шилжилтийн он жилүүдэд эдийн засаг хамгийн өндөр өсөлттэй (17.3%) байсан 2011 оны дараах 2012 онд хамгийн өндөр үзүүлэлттэй (25.4%) байжээ. Харин эдийн засгийн өсөлт бага (1.5%) байсан 2016 онд мөн сарын дундаж бодит орлого 11.0 хувиар буурсан байна. Мөн 2021 онд өрхийн сарын дундаж бодит орлогын жилийн өсөлтийн хурд 5.3 хувиар буурсан байна. 2022 онд өрхийн орлогын өсөлт 1.1 хувь, эдийн засгийн өсөлт 2022 онд 5.0 хувьтай байна.


►Зураг 3.8. Өрхийн сарын дундаж бодит орлогын өсөлт, эдийн засгийн өсөлт, хувиар



3.6. Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 2022 онд 2.6 сая болж, өмнөх оноос 62.0 (2.4%) мянган хүнээр өссөн байна.

► Зураг 3.9. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, жилээр, мянган хүн



Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдагчдын 48.1 хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмж авсан 18 хүртэлх насны хүүхдүүд, 10.8 хувь нь эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж авагчид, 12.4 хувь нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ авагчид, 28.7 хувь нь бусад төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид байна.

3.7. Хөдөлмөр

Ажиллах хүчний 2022 оны судалгаагаар ажиллах хүч 1.3 сая болж 2018 оныхоос 93.4 (6.9%) мянган хүнээр буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 894.4 мянга болж 26.4 (3.0%) мянган хүнээр өссөн байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2022 онд 58.6 хувь болж 2018 оныхоос 2.4 нэгж хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.7 хувь болж 1.6 нэгж хувиар буурсан нь хөдөлмөрийн насны хүн амын бүтцийн өөрчлөлтөөс гадна хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил суларсан байгааг харуулж байна.

► Хүснэгт 3.2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт, мянган хүн


Үзүүлэлт	2017	2018	2019*	2020	2021	2022
Ажиллах хүч	1 357.4	1 358.6	1 273.9	1 250.6	1 225.4	1 265.2
Ажиллагчид	1 238.3	1 253.0	1 146.2	1 162.9	1 125.6	1 180.5
Ажилгүй хүн	119.1	105.6	127.7	87.7	99.8	84.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	863.0	868.0	832.2	877.5	926.8	894.4
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	61.1	61.0	60.5	58.8	56.9	58.6
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	55.8	56.3	54.4	54.6	52.3	54.7
Ажилгүйдлийн түвшин, %	8.8	7.8	10.0	7.0	8.1	6.7

* Аргачлал шинэчлэгдсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2010 онд 55.5 хувь, эдийн засгийн өсөлтийн жилүүд болох 2011-2014 онд дунджаар 57.6 хувьд хүрч байсан бол 2022 онд 54.7 хувь болж 2010 онтой харьцуулахад 0.8 нэгж хувиар буурчээ.


Ажилгүйдлийн түвшнийг хүйсээр авч үзвэл, эмэгтэйчүүдийнх дунджаар 2010-2022 онд 7.6 хувь, эрэгтэйчүүдийнх 8.8 хувь байна. Харин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 2010-2022 онд дунджаар 11.4 нэгж хувиар бага, 2010 онтой харьцуулахад 2022 онд 2.6 нэгж хувиар буурсан байна. Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн асуудлын үндсэн шалтгаан нь гэрлэлт, гэр орны ажил болон бусдыг асран халамжлах үүрэг, хариуцлага, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил үүргийн талаарх нийгэмд тогтсон ойлголт, хэм хэмжээ, хүлээлт зэрэгтэй холбоотой байна.

►Зураг 3.10. Хөдөлмөр эрхлэлтийн болон ажилгүйдлийн түвшин, хүйсээр, хувиар



Сүүлийн 12 жилийн хугацаанд хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 33.5-аас 24.9 хувь болж, 8.6 нэгж хувиар буурч, аж үйлдвэр, барилгын салбарын ажиллагчид 5.6 нэгж хувиар, уул уурхайн салбарынх 1.8 нэгж хувиар, үйлчилгээний салбарынх 1.2 нэгж хувиар өссөн байна. Ажиллах хүч цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмж харьцангуй бага уламжлалт хөдөө аж ахуй салбараас аж үйлдвэр, үйлчилгээний салбарт шилжиж байна.

►Зураг 3.11. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар




3.8. Хүний хөгжлийн индекс

Хүний хөгжлийн индекс 2018 онд 0.759 байсан бол 2022 онд 0.781 болж, 0.022 нэгжээр нэмэгдэхэд боловсролын индекс 0.033 нэгжээр өссөн нь голлон нөлөөлсөн. Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс 2018 онд 0.670 байсан бол 2022 онд 0.703 болж, 0.033 нэгж хувиар нэмэгджээ. Тэгш бус байдлын улмаас алдагдсан боломж 2022 онд 10.0 хувь болж, 2018 оноос 0.033 нэгж хувиар нэмэгдсэн байна. Жендэрийн тэгш бус байдлын индекс 2022 онд 0.276 болж, 2018 оноос 0.012 нэгжээр буурсан байна.

Хүснэгт 3.3. Хүний хөгжлийн индекс

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Хүн амын дундаж наслалтын индекс	0.772	0.776	0.780	0.785	0.789
Хүн амын боловсролын түвшний индекс	0.721	0.725	0.761	0.761	0.754
ҮНО-ын индекс	0.784	0.790	0.784	0.784	0.801
Хүний хөгжлийн индекс	0.759	0.763	0.775	0.776	0.781
Дундаж наслалтын тэгш бус байдлаар засварласан индекс	0.685	0.688	0.694	0.698	0.703
Боловсролын тэгш бус байдлаар засварласан индекс	0.661	0.664	0.733	0.733	0.726
Орлогын тэгш бус байдлаар засварласан индекс	0.664	0.668	0.664	0.665	0.680
Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс	0.670	0.674	0.696	0.698	0.703
Жендэрийн тэгш бус байдлын индекс	0.288	0.274	0.286	0.367	0.276



4

ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Энэ бүлэгт хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа болон сургуульд хамрагдалтын зарим үр дүнг тусгав.


Хүүхдийн хөдөлмөр гэдэг нь 5-17 насны хүүхдийн бусдын болон өөрийн хэрэгцээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх аливаа үйл ажиллагааг багтаасан өргөн хүрээний ойлголт юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн ерөнхий хүрээн дэх ажил бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох ажил болон цалин хөлсгүй гэр үйлчилгээ (гэрийн ажил)-ний ажил юм. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох нь ҮТС-ийн үйлдвэрлэлийн хил хязгаар доторх ажилд оролцохыг хэлнэ. Энэхүү тайланд ҮТС-ийн үйлдвэрлэлийн хил хязгаарт хамаарах үйл ажиллагаануудад цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр, өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл болон цалин, хөлсгүй дадлагажих ажил орно.

► **Зураг 4.1. 5-17 насны хүүхдийн эдийн засгийн оролцоо**



Нийт хүүхдийн тодорхой хэсэг болох эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоог Веннийн дүрслэлийг ашиглан харуулав (Зураг 4.1).

► **Зураг 4.2. 5-17 насны хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа**



Судалгаагаар 5-17 насны хүүхдийн 208.0 мянга буюу 24.4 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон, 644.4 мянга буюу 75.6 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцоогүй байна.


Хөвгүүд охидоос илүү эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байна: Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа 5-17 насны хүүхдүүдийн 126.1 мянга буюу 60.7 хувь нь хөвгүүд, 81.8 мянга буюу 39.3 хувь нь охид байна. Харин байршлын хувьд 105.7 мянга (50.8%) нь хотод, суурин газарт, 102.2 мянга (49.2%) нь хөдөөд амьдарч байна.

►Хүснэгт 4.1. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхэд, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр


Үзүүлэлт	5-12 насны хүүхэд		13-14 насны хүүхэд		15-17 насны хүүхэд		Бүгд		
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
Бүгд	99 139	47.7	48 710	23.4	60 102	28.9	207 951	100.0	
Хүйс	Хөвгүүд	60 029	47.6	28 745	22.8	37 367	29.6	126 141	100.0
	Охид	39 110	47.8	19 965	24.4	22 735	27.8	81 810	100.0
	Хот	47 428	44.9	26 635	25.2	31 673	29.9	105 736	100.0
	Хөвгүүд	30 859	46.0	16 280	24.3	19 881	29.7	67 020	100.0
Байршил, Хүйс	Охид	16 569	42.8	10 355	26.7	11 792	30.5	38 716	100.0
	Хөдөө	51 711	50.6	22 075	21.6	28 429	27.8	102 215	100.0
	Хөвгүүд	29 170	49.3	12 465	21.1	17 486	29.6	59 121	100.0
	Охид	22 541	52.3	9 610	22.3	10 943	25.4	43 094	100.0
Бүс	Баруун бүс	29 800	54.9	11 167	20.6	13 292	24.5	54 259	100.0
	Хангайн бүс	18 606	43.7	10 493	24.7	13 467	31.6	42 566	100.0
	Төвийн бүс	11 291	42.6	5 983	22.6	9 215	34.8	26 489	100.0
Бүс	Зүүн бүс	7 444	48.0	3 917	25.2	4 163	26.8	15 524	100.0
	Улаанбаатар	31 998	46.3	17 150	24.8	19 965	28.9	69 113	100.0

Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн эзлэх хувь улсын хэмжээнд 24.4 хувь, хүйсийн хувьд хөвгүүдийнх 28.9 хувь, охидынх 17.7 хувь байна. Насны бүлгийн хувьд нас нэмэгдэх тусам хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэж байна.

▶ **Зураг 4.3. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, нас, хүйсээр**




▶ **Зураг 4.4. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, нас, байршлаар**



Байршлын хувьд хөдөөд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн хувь өндөр байна.


▶ **Зураг 4.5. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь, хүйс, байршил, насны бүлгээр**



Улсын түвшинд 5-17 насны нийт хүүхдэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь бүс нутгаар ихээхэн ялгаатай байна. Баруун бүс (48.7%), Хангайн бүс (27.7%), Зүүн бүс (26.9%-д 5-17 насны хүүхдүүдийн дийлэнх нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нь улсын дундажтай харьцуулахад их байна. Төвийн бүсэд 20.3 хувь, Улаанбаатар хотод 17.3 хувь байгаа нь улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна.


Аймгийн түвшинд ч ихээхэн ялгаатай байна: Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймагт 51.3-55.2 хувь байгаа бол Хэнтий, Баянхонгор, Дорнод, Орхон аймагт 24.8-28.8 хувь байна (Хавсралт хүснэгт 12-оос харна уу).

► **Зураг 4.6. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхэд, насны бүлэг, аймгаар**



Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийг оролцсон ажлын хэлбэрээр нь авч үзэхэд, арван хүүхэд тутмын гурав нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н бус үйлдвэрлэлд оролцсон, хоёр нь өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н болон ХАА-н бус үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамтад нь оролцсон, хоёр нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцсон байна. Энэ хандлага хүйс болон насны бүлэгт хадгалагдаж байгаа бол байршлын хувьд нэлээд ялгаатай байна. Хотод хүүхдүүд зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н бус бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд илүү их оролцсон бол хөдөөд хүүхдүүд өөрийн эцсийн хэрэглээний (ХАА-н болон ХАА-н бус аль аль нь) бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд илүү их оролцсон байна.


► **Зураг 4.7. 5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхэд, ажлын хэлбэр, хүйс, байршил, насны бүлгээр**



Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 “Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй” гэж заасны дагуу энэхүү тайланд сургуульд хамрагдалтыг 6-14 насны хүүхдээр онцлон авч, харин 15-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалтыг харьцуулах зорилгоор тусгасан.

6-14 насны нийт хүүхдийн 21.8 хувь нь суралцахын зэрэгцээ эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон бол зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, сургуульд суралцдаггүй хүүхдүүд 0.6 хувийг, зөвхөн сургууль суралцагчид 73.3 хувийг, сургуульд сурдаггүй, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдоггүй хүүхэд 4.3 хувийг эзэлж байна.


▶ **Зураг 4.8. Хүүхдийн сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагааны оролцоо, насны бүлгээр**



6-14 насны хүүхдүүдтэй харьцуулахад 15-17 насны хүүхдүүд зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо болон эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохын зэрэгцээ сургуульд суралцах нь нэмэгдэж, харин зөвхөн сургуульд суралцах нь 54.3% буурч байна.

Хүүхдүүдийн дийлэнх нь 6 настайдаа сургуульд ордог боловч судалгааны хугацаанд 6 настай хүүхдүүдийн 30 гаруй хувь нь сургууль сураагүй, мөн 5 настай хүүхдүүдийн 6 хувь нь цэцэрлэгт хамрагдсан байна. Энэ нь судалгаанд хамрагдах хугацаанд хичээлийн жил эхлээгүй байснаас шалтгаалсан байх талтай.


► **Зураг 4.9. Хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагаа, насаар**



► **Хүснэгт 4.2. 6-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт болон эдийн засгийн үйл ажиллагаа, хүйс, байршлаар**

Үзүүлэлт	6-14 насны хүүхэд	Үйл ажиллагаагаар:									
		Зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон		Зөвхөн сургуульд суралцдаг		Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохын зэрэгцээ сургуульд суралцсан		Аль нь ч биш			
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%		
Бүгд	644 796	100.0	3 871	100.0	472 617	100.0	140 544	100.0	27 764	100.0	
Хүйс	Хөвгүүд	329 639	51.1	2 423	62.6	227 239	48.1	84 469	60.1	15 508	55.9
	Охид	315 157	48.9	1 448	37.4	245 378	51.9	56 075	39.9	12 256	44.1
Байршил, хүйс	Хот	452 849	100.0	934	100.0	358 917	100.0	72 336	100.0	20 662	100.0
	Хөвгүүд	229 975	50.8	552	59.1	171 229	47.7	46 084	63.7	12 110	58.6
	Охид	222 874	49.2	382	40.9	187 688	52.3	26 252	36.3	8 552	41.4
	Хөдөө	191 947	100.0	2 937	100.0	113 700	100.0	68 208	100.0	7 102	100.0
	Хөвгүүд	99 664	51.9	1 871	63.7	56 010	49.3	38 385	56.3	3 398	47.8
Охид	92 283	48.1	1 066	36.3	57 690	50.7	29 823	43.7	3 704	52.2	





5

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР




Хүүхдийн хөдөлмөр нь хүүхдийн ажил эрхлэлт гэсэн ойлголтоос илүү нарийвчилсан өөр ойлголт юм. Өөрөөр хэлбэл, бага насны хүүхэд хүүхдийн хөдөлмөрт оролцох боломжгүй, учир нь бие бялдар, оюун санааны хөгжилд нь сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаанд оролцуулж байгаа тул хууль тогтоомжоор хориглосон ажилд хүүхдийг оролцуулж байгаа тухай ойлголт юм. Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн тоон мэдээллийг бий болгосноор хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх, сурч боловсроход саад учруулах нөхцөлд байгаа эсэхийг тодорхойлох боломжтой болдог.

Энэ бүлэгт хүүхдийн хөдөлмөр, аюултай ажил эрхэлж буй хүүхэд, тэдний үндсэн үйл ажиллагааны шинж чанар болон оролцож буй ажлын хэлбэр, зарцуулсан цаг гэх зэрэг мэдээллийг тусгав.

Улсын хэмжээнд 5-17 насны хүүхдийн 138.5 мянга буюу 16.3 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцож байгаа нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон нийт хүүхдийн 66.6 хувийг эзэлж байна. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин хүйсийн хувьд хөвгүүд охидоос 7.4 нэгж хувиар их байна (Хөвгүүдийнх 19.9%, охидынх 12.5%).


Хүүхдийн хөдөлмөр бүс нутаг болон байршлын хувьд мэдэгдэхүйц ялгаатай байна. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин хөдөөд 30.0 хувь байгаа нь хот суурин газрынхаас 19.8 нэгж хувиар илүү байна. Бүс нутгийн хувьд, Улаанбаатар хотод хамгийн бага (10.0%), Баруун бүсэд хамгийн өндөр (36.3%) байна.

Зураг 5.1. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр



Хүүхдийн хөдөлмөрийн түвшин Ховд (45.4%), Баян-Өлгий (43.1%), Говь-Алтай (42.3%) аймагт хамгийн өндөр байна. Харин Сэлэнгэ, Булган, Өвөрхангай аймагт 5-17 насны дөрвөн хүүхэд тутмын нэг нь, Завхан, Увс, Архангай, Дорнод, Дундговь, Хэнтий, Баянхонгор, Сүхбаатар аймагт 5-17 насны таван хүүхэд тутмын нэг нь хүүхдийн хөдөлмөрт оролцож байна.

►Зураг 5.2. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, аймаг, нийслэлээр



►Зураг 5.3. Хүүхдийн хөдөлмөр, ангиллаар




Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг олон улсын аргачлал болон үндэсний хууль эрх зүйн заалтад тулгуурлан тооцсон ангиллын дагуу авч үзэхэд, тэдний 78.2 мянга (56.5%) нь хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хөнгөн ажлыг хийж болохуйц наснаас доош нас (5-12 нас)-ны хүүхдүүд, 58.2 мянга (42.0%) нь аюултай ажил эрхэлж байгаа 5-17 насны хүүхдүүд, 2.1 мянга (1.5%) нь аюулгүй ч хөнгөн бус хөдөлмөр эрхэлж буй 13-14 насны хүүхдүүд байна.

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 86.7 мянга (62.6%) хөвгүүд, 51.8 мянга (37.4%) нь охид, насны хувьд 99.1 мянга (71.6%) нь 5-12 насныхан, 15.9 мянга (11.4%) нь 13-14 насныхан, 23.5 мянга (17.0%) нь 15-17 насныхан байна.

Хөдөлмөр эрхэлж буй таван хүүхэд тутмын гурав нь хөдөөд амьдарч байгаа бол бүсийн хувьд арван хүүхэд тутмын гурав нь Улаанбаатар хотод, мөн гурав нь Баруун бүсэд амьдарч байна. Хэдийгээр нийт хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн дүнд Улаанбаатар хотод амьдарч байгаа хүүхдийн эзлэх хувь өндөр (32.3%) байгаа ч Улаанбаатар хотын 5-17 насны нийт хүүхдэд эзлэх хувь буюу хүүхдийн хөдөлмөрийн түвшнээр хамгийн бага (10.0%) дүнтэй байна. Энэ нь Монгол Улсын нүүдлийн мал аж ахуй эрхлэлт, ахуйн соёл болон дэд бүтцийн асуудалтай холбоотой.


▶Зураг 5.4. Хүүхдийн хөдөлмөр, нас, хүйс, дүнд эзлэх хувиар




Дээрх зургаас харахад, 12 нас хүртэл хүүхдийн нас нэмэгдэх тусам хүүхдийн хөдөлмөрт оролцох нь нэмэгдэж, 13 насанд буурч, 14 наснаас дахин нэмэгдэж байна. Энэ нь хүүхдийг, ялангуяа хөнгөн ажилд орох наснаас доош насны хүүхдийн хувьд эдийн засгийн үйл ажиллагаа (өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл орсон)-нд ихээр оролцсон (Бүлэг 4)-оор Монгол Улсын хүүхдүүд багаасаа хөдөлмөрийн зах зээлд орж байгааг, 13 наснаас хойш тэдний оролцоо харьцангуй тогтвортой байгааг харуулж байна. Энэ нь нэг талаасаа 13 наснаас эхлэн хүүхдүүд өөрийн насны онцлогт тохирсон хуулиар зөвшөөрөгдсөн, аюултай бус үйл ажиллагаанд оролцох боломжтой (энэ нь хүүхдийн хөдөлмөрт тооцогдохгүй) тул тухайн наснаас эхлэн хүүхдийн хөдөлмөрийн түвшин 20 хувиас бага болж буурч байна.

Бүх насны хөвгүүд охидоос илүү хүүхдийн хөдөлмөрт оролцож байна. Үүний нэгэн адил нас харгалзахгүй, хөдөөд хот, суурин газраас хүүхдийн хөдөлмөр өндөр байна.

▶Зураг 5.5. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, нас, хүйсээр



►Зураг 5.6. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, байршлаар




5.1. Үндсэн ажлын онцлог

Хүүдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд хэд хэдэн ажлын хэлбэрт давхар оролцох боломжтой. Иймд энэ бүлэгт хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн үндсэн ажлын буюу хамгийн их цаг зарцуулж буй ажлынх нь талаар дурдсан.

Доорх Зураг 5.6-д үзүүлснээр, хүүхдийн хөдөлмөрт оролцож буй 5-17 насны хоёр хүүхэд тутмын нэг нь өрхийн хэрэглээнд зориулж байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөх, түлээ бэлтгэх үйл ажиллагаанд, арван хүүхэд тутмын гурав нь мал аж ахуй эрхлэх, нэг нь газар тариалан эрхлэх үйл ажиллагаанд оролцсон байна.

►Зураг 5.7. Хүүхдийн хөдөлмөр, эдийн засгийн үндсэн үйл ажиллагааны салбар, дүнд эзлэх хувиар



- Газар тариалан, ан агнуур
- Мал аж ахуй
- Боловсруулах үйлдвэрлэл
- Барилга
- Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ
- Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ
- Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа
- Бусад гэрийн ажил /ус зөөх, түлээ бэлтгэх/
- Бусад

5.2. Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн ажлын хэлбэр

Энэ хэсэгт ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний хил хязгаар дах хүүхдийн хөдөлмөрийг тусгав.


Ажлын хэлбэрүүдийг Олон улсын хөдөлмөрийн статистикчдийн 19 дүгээр бага хурлаас баталсан “Ажил, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалтын тухай” тогтоолд тусгасан ойлголт, тодорхойлолттой нийцүүлэн тодорхойлсон. Ингэснээр зах зээлд чиглэсэн бараа, үйлчилгээний үйлдвэрлэл эсвэл өөрийн өрхийн эцсийн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд оролцож буй хүүхдийг тодорхойлж, хүүхдийн хөдөлмөрт оролцож байгаа хүүхдийг бүрэн хэмжих боломжтой (Өөрийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулсан үйлчилгээ, гэрийн ажлын талаар Бүлэг 8-д тусгайлан авч үзсэн).

Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй 138.5 мянган хүүхдүүдийн 126.6 мянга (91.4%) нь зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд, 5.1 мянга (3.7%) нь зөвхөн цалин хөлс, орлого олох үйл ажиллагаанд, 212 (0.2%) нь зөвхөн цалин хөлсгүй дадлагажих үйл ажиллагаанд оролцсон бол 6.5 мянга (4.7%) нь эдгээр үйл ажиллагааны аль алинд нь давхар оролцсон байна.

Хүснэгт 5.1. Хүүхдийн хөдөлмөр, ажлын хэлбэрээр, насны бүлэг, хүйс, байршлаар

Үзүүлэлт	Зөвхөн цалин хөлс, орлого олох ажил		Зөвхөн өрхийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил		Зөвхөн цалин хөлсгүй дадлагажих ажил		Цалин хөлс, орлого олох ажил болон өрхийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил аль нь		Өрхийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил болон цалин хөлсгүй дадлагажих ажил аль нь		Нийт өөрийн эцсийн хэрэглээний үйл ажиллагаа (b+d+e)		Тоо	%
	(a)	(b)	(c)	(d)	(e)	(b+d+e)	(b+d+e)	(b+d+e)	(b+d+e)	(b+d+e)	(b+d+e)			
Бүгд	5 061	126 617	91.4	212	0.1	6 508	4.7	127	0.1	133 252	138 525	100.0		
Хүйс	3 135	78 488	90.5	145	0.2	4 873	5.6	83	0.1	83 444	86 724	100.0		
Охид	1 926	48 129	92.9	67	0.1	1 635	3.2	44	0.1	49 808	51 801	100.0		
5 - 12 нас	1 829	95 702	96.5			1 597	1.6	12	0.0	97 311	99 140	100.0		
13 - 14 нас	1 133	13 311	83.8			1 438	9.1			14 749	15 882	100.0		
15 - 17 нас	2 099	17 604	74.9	212	0.9	3 473	14.8	115	0.5	21 192	23 503	100.0		
Хот	3 530	53 811	88.6	163	0.3	3 125	5.1	115	0.2	57 051	60 744	100.0		
Хөдөө	1 531	72 806	93.6	49	0.1	3 383	4.3	12	0.0	76 201	77 781	100.0		
Баруун бүс	304	39 435	97.3			781	1.9			40 216	40 520	100.0		
Хангайн бүс	1 124	25 621	88.1	123	0.4	2 167	7.4	54	0.2	27 842	29 089	100.0		
Төвийн бүс	962	16 191	91.8			486	2.8			16 677	17 639	100.0		
Зүүн бүс	840	9 710	83.7			1 060	9.1			10 770	11 610	100.0		
Улаанбаатар	1 831	35 660	89.9	89	0.2	2 014	5.1	73	0.2	37 747	39 667	100.0		

▶ **Зураг 5.8. Хүүхдийн хөдөлмөр болон ажлын хэлбэр**



Ажлын аль ч хэлбэр нь бие биеэсээ үл хамаарах үйл ажиллагаа биш бөгөөд цалин хөлс, орлого олох зорилготой ажил эрхэлж буй зарим хүүхдүүд өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эсвэл бусад үйл ажиллагааны аль алинд нь давхар оролцсон байх талтай. Иймд ерөнхий дүр зургийг бүхэлд нь харуулахын тулд Веннийн диаграм ашиглан хүүхдийн хөдөлмөрт оролцож буй нийт хүүхэд, тэдгээрийн ямар ажлын хэлбэрт оролцож байгааг харууллаа.

5.2.1. Цалин хөлс, орлого олох зорилготой хөдөлмөр эрхэлж буй хүүхэд

Энэ хэсэгт хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдээс цалин хөлс, орлого олох зорилгоор оролцсон хүүхдийн талаар тусгав.

Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй нийт хүүхдийн 11.6 мянга нь цалин хөлс, орлого олох зорилгоор оролцсон байна. Хүүхдийн хөдөлмөрт оролцсон арван хүүхэд тутмын дөрөв (5.1 мянга) нь зөвхөн уг үйл ажиллагаанд оролцсон, зургаа нь (6.5 мянга) нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд давхар оролцсон байна.

Цалин хөлс, орлого олох зорилготой хүүхдийн хөдөлмөрт оролцсон арван хүүхэд тутмын долоо нь хөвгүүд байна. Байршлын хувьд хот, суурин газарт хүүхэд хүүхдийн хөдөлмөрт оролцох нь илүү байгаа бол бүс нутгийн хувьд Улаанбаатар болон Хангайн бүсэд бусад бүсээс өндөр байна.

Насны хувьд, цалин, орлого олох зорилготой хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхдүүдийн дийлэнх хувийг 15-17 насны хүүхэд эзэлж байна. Тэд ихэвчлэн аж үйлдвэр, барилгын салбарын үйл ажиллагаанд ихээр ажиллаж байна. Харин бага насныхан буюу 5-14 болон 13-14 насныхны ихэнх нь хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаанд оролцсон байна.


►Хүснэгт 5.2. Цалин хөлс, орлого олох зорилготой хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагаа, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр

Үзүүлэлт	Бүгд		Эдийн засгийн салбараар, хувиар					Бүгд
	Тоо	%	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ	Өрхийн сектор		
Бүгд	11 569	100.0	50.5	22.7	25.0	1.8	100.0	
Хүйс	Хөвгүүд	8 008	69.2	52.7	26.1	20.2	1.0	100.0
	Охид	3 561	30.8	45.7	15.1	35.7	3.5	100.0
Насны бүлэг	5 - 12 нас	3 427	29.6	75.4	9.0	12.4	3.2	100.0
	13 - 14 нас	2 571	22.2	58.1	10.0	31.9	-	100.0
	15 - 17 нас	5 571	48.2	31.8	37.0	29.5	1.7	100.0
Байршил	Хот	6 655	57.5	26.0	33.9	37.0	3.1	100.0
	Хөдөө	4 914	42.5	83.7	7.5	8.8	-	100.0
	Баруун бүс	1 085	9.4	55.9	9.2	34.9	-	100.0
	Хангайн бүс	3 292	28.5	61.0	23.5	14.1	1.4	100.0
Бүс	Төвийн бүс	1 448	12.5	66.0	13.1	20.9	-	100.0
	Зүүн бүс	1 900	16.4	79.6	7.7	12.7	-	100.0
	Улаанбаатар	3 845	33.2	19.8	36.9	39.1	4.2	100.0

Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн 4.7 мянга (40.9%) нь мал аж ахуйн салбарт, 2.0 мянга (17.3%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 1.6 мянга (14.1%) боловсруулах үйлдвэрлэлийн, 1.1 мянга (9.6%) нь газар тариалан, ойн аж ахуйн, 1.0 мянга (8.4%) нь барилгын салбарт ажилласан байна. Улсын түвшинд хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхдүүдийн ихэнх нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа хандлага хүйсийн хувьд ч ажиглагдаж байгаа ч охид хөвгүүдийг бодвол үйлчилгээний салбар болон өрхийн секторт илүү ажиллаж, хөвгүүд охидоос илүү аж үйлдвэр, барилгын салбарт ажиллаж байна.


Цалин хөлс, орлого олох зорилготой хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүд байршлын хувьд эдийн засгийн үйл ажиллагааны салбар нь нэлээд ялгаатай байна. Тухайлбал, хөдөөд цалин хөлс, орлого олохоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн ихэнх нь мал аж ахуй эрхэлж байгаа бол хот, суурин газарт бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажилласан байна.

► **Зураг 5.9. Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, дүнд эзлэх хувиар**



Статусын хувьд хүүхдийн хөдөлмөрт оролцож буй нийт хүүхдийн 9.5 мянга (81.8%) нь гэр бүлийн гишүүдэд хувь нэмэр оруулагч, 2.0 мянга (17.0%) нь цалин хөлстэй ажиллагч байна. Байршлаар авч үзэхэд хот, хөдөөгийн аль алинд нь, бүх насны бүлэгт хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн дийлэнх нь гэр бүлийн гишүүдэд хувь нэмэр оруулахаар ажиллаж байна.


► **Зураг 5.10. Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд, статус, хүйс, байршил, насны бүлэг, хувиар**



Цалин хөлс, орлого олох зорилготой хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхдүүд сард дунджаар 661.3 мянган төгрөгийн цалин хөлс, орлого олсон байна.


Салбарын хувьд хөдөө аж ахуйн салбарт 764.9 мянга, аж үйлдвэр, барилгын салбарт 699.3 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 38.0-103.6 мянган төгрөгөөр их байна. Хүйсийн хувьд, үйлчилгээний салбарт ажиллаж буй охид хөвгүүдээс 26.7 хувиар илүү цалин хөлс, орлого олж байгаа бол бусад салбарын хувьд хөвгүүд охидоос илүү цалин хөлс, орлого олж байна. Байршлын хувьд, хөдөө орон нутагт цалин, орлого өндөр байгаа ба хүүхдийн нас нэмэгдэх тусам цалин, орлого нэмэгдэж байна.

► **Зураг 5.11. Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн сарын дундаж цалин, орлого, хүйс, байршил, насны бүлэг, хувиар**




Цалин хөлс, орлого олох зорилготой ажиллаж байгаа 5-17 насны хүүхдүүд үндсэн үйл ажиллагаандаа долоо хоногт дунджаар 19 цаг зарцуулж байна. Хүйсийн хувьд, охид хөвгүүдээс 2 цагаар их цаг зарцуулж байна. Байршлын хувьд, ихээхэн ялгаатай байгаа бөгөөд хот, суурин газарт ажилладаг хүүхдүүд хөдөө амьдарч буй хүүхдээс илүү их цагаар ажиллаж байна.

► **Зураг 5.12. Хүүхдийн цалин хөлс, орлого олох ажилд зарцуулсан цаг, салбар, хүйс, байршил, насны бүлгээр**



► **Зураг 5.13. Цалин хөлс, орлого олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн сургуульд хамрагдалт, хувиар**



Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй 6-14 (суурь боловсрол эзэмших нас) насны хүүхдүүдийн дийлэнх нь сургуульд суралцаж байгаа бөгөөд хүүхдийн хөдөлмөрт оролцож буй охид бүгд сургууль суралцаж байна. Байршлын хувьд, хөдөө орон нутагт сургуульд сурдаггүй зөвхөн хүүхдийн хөдөлмөрт оролцдог хүүхэд хот суурин газрынхаас их байна.

5.2.2. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхэд

Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн 133.2 мянга (96.2%) нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцсон байна. Зураг 5.8-д нэгээс олон үйл ажиллагаанд оролцсон хүүхдийг харуулсанчлан, тэдгээрийн 6.6 мянга (5.0%) нь уг үйл ажиллагаанд оролцохдоо цалин хөлс, орлого олох үйл ажиллагаанд давхар оролцсон байна.

Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхдүүдийн 83.4 мянга буюу 62.6 хувь нь хөвгүүд, 49.8 мянга буюу 37.4 хувь нь охид, байршлын хувьд 57.0 мянга буюу 42.8 хувь нь хот, суурин газарт, 76.2 мянга буюу 57.2 хувь нь хөдөө амьдарч байна.


►Хүснэгт 5.3. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхэд, үйл ажиллагааны төрөл, хүйс, байршил, хувиар

Үйл ажиллагаа	Тоо	Бүгд	Хөвгүүд	Охид	Хот	Хөдөө
Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхэд	Тоо Хувь	133 252 100	83 444 62.6	49 808 37.4	57 050 42.8	76 202 57.2
Оролцсон үйл ажиллагаагаар, хувиар						
Газар тариалан		0.8	0.6	1.2	0.8	0.8
Мал, тэжээвэр амьтан өсгөх		35.8	35.8	35.8	9.1	55.9
Ойн аж ахуй, мод бэлтгэл		0.6	0.7	0.4	0.0	1.0
Байгалаас жимс, мөөг зэрэг бусад хүнсний бүтээгдэхүүн цуглуулах		0.9	0.6	1.4	1.2	0.7
Ан агнах		0.1	0.0	0.2	0.1	0.1
Хоол хүнсийг хадгалах, нөөцлөх зориулалтаар бэлтгэх		2.6	2.2	3.3	1.5	3.4
Ахуйн зориулалттай байгууламж шинээр барих, засварлах		2.9	3.6	1.9	1.0	4.4
Юм оёох, ширээ, сандал засварлах гэх мэт ахуйн хэрэглээний бусад зүйлсийг шинээр хийх, засварлах		2.3	2.1	2.6	0.8	3.4
Байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөх		66.0	69.0	61.0	85.5	51.4
Түлээ бэлтгэх		38.0	38.2	37.7	29.1	44.7


Тайлбар: Хүүхэд нэгээс олон үйл ажиллагаанд оролцож болох тул нийлбэр дүн 100%-иас их байна.

Мөн хүүхдүүд хүүхдийн хөдөлмөрийн өөрийн эцсийн хэрэглээний хэд хэдэн төрлийн үйл ажиллагаанд давхар оролцсон байна. Тэдний ихэнх нь (88.0 мянга буюу 66.0%) өрхийн хэрэглээндээ зориулж байгалийн болон нийтийн эх үүсвэрээс ус зөөх нь өрхийн хэрэглээндээ зориулж түлээ бэлтгэх (50.7 мянга буюу 38.0%) болон өрхийн хэрэгцээндээ зориулан мал, тэжээвэр амьтан өсгөх, үржүүлэх (47.7 мянга буюу 35.8%) үйл ажиллагаанд оролцсон байна. Эдгээр хүүхдийн хөдөлмөрийн үйл ажиллагаанд хүүхдийн оролцоо аль ч насанд их байна (Зураг 5.14). Энэ хандлага хүйсийн хувьд хадгалагдаж байгаа ч байршлын хувьд хөдөөд хот, суурин газраас мал аж ахуйн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь 46.8 нэгж хувиар, түлээ бэлтгэх үйл ажиллагааных 15.6 нэгж хувиар их байна. Харин байгалийн эсвэл нийтийн эх үүсвэрээс ус зөөсөн хүүхдийн эзлэх хувь хот, суурин газарт хөдөөгийнхөөс 34.1 нэгж хувиар их байна. Энэ нь хот, суурин газрын дэд бүтэц, насанд хүрэгчдийн ажлын цаг урт байгаа зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байх талтай. Харин хөдөөд ердийн хөсөг эсвэл авто машинаар насанд хүрэгчид ус зөөх хандлага илүү байдаг бол хот, суурин газар хүүхэд, багачууд нийтийн эх үүсвэрээс ус авахаар үүссэн дараалалд багагүй хугацаа зарцуулан ус авах хандлага их байдаг.

▶ **Зураг 5.14. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхэд, үйл ажиллагааны төрөл, насны бүлэг, дүнд эзлэх хувиар**




▶ **Зураг 5.15. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхдийн долоо хоногт зарцуулсан дундаж цаг, үйл ажиллагааны төрөл, хүйс, байршил, насны бүлгээр**



Хүүхдүүд долоо хоногт дунджаар 7 цагийн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажилд зарцуулж байна. Хүйсийн хувьд хөвгүүд энэ үйл ажиллагаанд охидоос 1 цаг илүү зарцуулж байна. Хөдөө амьдарч буй хүүхдүүдийн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэхэд зарцуулж буй долоо хоногийн дундаж цаг нь хот, суурин газарт амьдарч буй хүүхдүүдийнхээс гурав дахин их байна.

Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож байгаа 6-14 насны 108.6 мянган хүүхэд байгаагийн 96.6 хувь нь сургуульд сурдаг, 3.4 хувь нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна. Уг хандлага хүйсийн хувьд хадгалагдаж, харин байршлын хувьд хот суурин газрын хүүхдүүд хөдөөгийн хүүхдээс илүү сургуульд суралцаж, хөдөөд 4.6 хувь, хот, суурин газарт 1.9 хувь нь сургуульд сурдаггүй хүүхэд байна. Эдгээр сургуульд сурдаггүй хүүхдийн 58.9 хувь нь 6 настай, 11.8 хувь нь 7 настай хүүхдүүд байна.

► **Зураг 5.16. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцож буй хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, байршил, насны бүлгээр, хувиар**




5.3. Ажлын цаг

Өмнөх дэд бүлгүүдэд зөвхөн тухайн ажлын хэлбэрүүдэд зарцуулсан цаг хугацааны мэдээллийг тусгасан бол энэ хэсэгт хүүхдийн ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний бүх үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийн мэдээллийг тусгав. Хүүхдүүд хүүхдийн хөдөлмөрт их цаг зарцуулах тусам ажлаас үүдсэн өвчлөл, осол гэмтэлд өртөх эрсдэл нэмэгдэх, сургуульд явах, хичээлээ давтах, чөлөөт цагаа өнгөрөөх, хангалттай амрах нь хязгаарлагдах зэрэг маш олон сөрөг үр дагавартай тул ажлын цагийн мэдээлэл нь чухал ач холбогдолтой.

Судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн бүх ажлын хэлбэрийн хувьд сүүлийн долоо хоногт жинхэнэ ажилласан цагийн мэдээллийг цуглуулсан тул ажлын цагийн үр дүнг жинхэнэ ажилласан цагаар тооцсон. Харин тогтмол ажилладаг цагийн мэдээллийг зөвхөн цалин хөлс, орлого олох ажлын хувьд л цуглуулсан.

► **Зураг 5.17. Долоо хоногийн дундаж цаг, хүйс, байршил, насны бүлгээр**



Хүүхдүүд долоо хоногт дунджаар 8 цаг хүүхдийн хөдөлмөр (хүүхдийн хөдөлмөрийн бүх ажлын хэлбэрүүдэд зарцуулсан нийт цагийн дундаж)-т оролцож байгаа бол хүйсийн хувьд, хөвгүүд (8 цаг) охид (7 цаг)-оос 1 цаг илүү зарцуулж байна.


Хөдөө орон нутгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс хоёр дахин их цаг хүүхдийн хөдөлмөрт оролцож байна. Тухайлбал, хөдөө амьдарч буй хүүхдүүд 10 цаг, хот, суурин газрын хүүхдүүд 5 цаг оролцож байна. Харин хүүхдийн оролцож буй ажлын хэлбэр болон амьдарч буй газрын байршлаас хамаараад хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан хугацаа харилцан адилгүй байна.

▶ Хүснэгт 5.4. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан долоо хоногийн дундаж цаг, насны бүлэг, ажлын хэлбэр, хүйс, байршлаар

Үзүүлэлт	5-12 насны хүүхэд					13-14 насны хүүхэд					15-17 насны хүүхэд				
	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэл болон цалин, орлого олох зорилготой ажил	Хүүхдийн хөдөлмөр (бүх ажил)	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэл болон цалин, орлого олох зорилготой ажил	Хүүхдийн хөдөлмөр (бүх ажил)	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэл болон цалин, орлого олох зорилготой ажил	Хүүхдийн хөдөлмөр (бүх ажил)			
Нийт	5	8	22	5	11	23	23	13	12	18	25	15			
Хүйс															
Хөвгүүд	5	12	19	5	12	25	33	14	9	26	30	12			
Охид	3	10	13	3	8	25	18	12	6	24	25	14			
Хот	3	9	12	3	7	24	19	11	7	20	24	14			
Хөвгүүд	2	12	13	3	10	25	2	14	5	31	28	15			
Охид	7	8	24	7	12	19	32	14	13	12	28	14			
Хөдөө	8	7	26	8	12	19	29	13	15	14	27	16			
Хөвгүүд	6	12	21	7	12	17	34	14	10	8	34	11			
Охид	5	9	21	5	11	24	26	13	11	21	26	14			

Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй арван хүүхэд тутмын найм нь 1-10 цаг зарцуулсан байна. Байршлын хувьд хөдөөд их цагаар ажиллаж буй хүүхдүүдийн эзлэх хувь өндөр байгаа буюу тэдний 30.2% нь долоо хоногт 11 болон түүнээс дээш цагийг хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан байна. Хүүхдийн хөдөлмөрт олон цаг зарцуулсан хүүхдийн эзлэх хувь хүүхдийн нас нэмэгдэх тусам нэмэгдэж байна. Тухайлбал, 5-12 насны хүүхдүүдийн 0.9% нь 41 болон түүнээс их цагаар ажилласан бол 13-14 насныхан 4.4%, 15-17 насныхан 11.9%-д хүрч нэмэгдэж байна.

▶ Зураг 5.18. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан долоо хоногийн дундаж цаг, ҮТС үйлдвэрлэлийн хүрээнд, цагийн интервалиар, хувиар



Сургуульд суралцангаа хүүхдийн хөдөлмөрт оролцож буй 6-14 насны хүүхдүүд долоо хоногт дунджаар 7 цаг зарцуулж байгаа бол сурдаггүй, зөвхөн хүүхдийн хөдөлмөрт оролцдог хүүхдүүд 10 цаг зарцуулж байна.

►Хүснэгт 5.5. Хүүхдийн хөдөлмөрт зарцуулсан цаг, сургуульд хамрагдалтын байдлаар

Үзүүлэлт	Суралцангаа хүүхдийн хөдөлмөрт оролцсон				Зөвхөн хүүхдийн хөдөлмөрт оролцсон			
	Бүгд	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Хоёулан нь оролцсон	Бүгд	Зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Зөвхөн цалин, орлого олох зорилготой ажил	Хоёулан нь оролцсон
Бүгд	7	5	11	23	10	7	26	25
Хөвгүүд	7	5	9	23	12	9	26	25
Охид	7	5	15	25	6	5	-	-
Хот	4	3	14	16	5	2	-	27
Хөвгүүд	4	3	11	16	6	2	-	27
Охид	4	3	17	12	3	3	-	-
Хөдөө	9	7	7	27	11	9	26	23
Хөвгүүд	10	8	6	27	14	11	26	23
Охид	8	7	8	27	7	5	-	-


5.4. Ажлын байрны нөхцөл

Хүүхдийн хөдөлмөрийг хүүхдийн нас, ажилласан цагаар нь тодорхойлохоос гадна хүүхдийн оролцож буй үйл ажиллагааны ажлын байрны нөхцөл нь тухайн хүүхдийн эрүүл мэнд, бие бялдарт хор хохирол учруулж болохуйц байгаа эсэхийг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Ажлын байрны нөхцөл гэдэг нь хүүхэд эсвэл насанд хүрэгчдийн ажиллаж буй ажлын байрны орчин тойрон, нийгмийн бодит байдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тодорхой ажлын байран дээрх хөдөлмөрийн үйл явц, ажлын байрны байршилд хамаарах нөхцөл юм.

Иймд хүүхдийн хөдөлмөрөөс үүдэн осол, гэмтэлд өртсөн, эсвэл дарамт, хүчирхийллээс үүдэн бие махбод, сэтгэл зүйн хувьд гэмтэл авч байсан талаарх мэдээллийг судалгаагаар цуглуулсан.

Судалгаагаар хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн 44.8 мянга буюу 32.4 хувь нь ажлын байрандаа айдас, аюултай байдлыг мэдэрч, 6.5 мянга буюу 4.7 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцох явцдаа осолд өртөж, гэмтэл авч, 5.4 мянга буюу 3.9 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцох явцдаа бусдад дээрэлхүүлж байсан бол 0.4 мянга буюу 0.3 хувь нь ажлын байрны хүчирхийллээс үүдэн гэмтэл авч байсан байна.

▶ **Зураг 5.19. Ажлын нөхцөл, тулгарсан хүндрэлээр**




Хүүхдийн хөдөлмөрт оролцох явцдаа осол, гэмтэл авч байсан хүүхдүүдийг осол, гэмтлийн төрлөөр авч үзэхэд, эд зүйлд цохиулж гэмтэх нь хамгийн их (1.7%) тохиолддог нь ажиглагдаж байна. Мөн хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн 1.3 хувь нь мал, амьтанд хазуулсан, 1.0 хувь нь өндрөөс эсвэл эд зүйл дээрээс унасан байна.

▶ **Зураг 5.20. Хүүхдийн хөдөлмөрт оролцох явцдаа осол, гэмтэл авсан тохиолдол, төрлөөр**



Мөн хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхдүүдийн 1.3 хувь нь хөдөлмөрлөх явцдаа бэртэж яс нь хугарч байсан төдийгүй багагүй хүүхдүүд биеийн аль нэг хэсгийг тайруулж байжээ. Энэ нь хэдийгээр бага тоо мэт харагдаж байгаа ч хүүхдийн хөдөлмөрт оролцоноос үүдэн бэртэж, гэмтэх асуудал байсаар байгааг, хүүхэд хамгааллын чиглэлээр анхаарах асуудлын нэг хэвээр байгааг харуулж байна.

►Зураг 5.21. Хүүхдийн хөдөлмөрт оролцох явцдаа өвдсөн тохиолдол, үүссэн өвчнөөр



5.5. Хүүхдийн аюултай ажилд оролцож буй хүүхэд

Монгол Улс 2001 онд нэгдэн орсон Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцын 3 дугаар зүйлд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлсон байдаг. Үүнд:


1. Боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдаалах, дамжуулан худалдаалах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөр эрхлүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа;
2. Хүүхдийн биеийг үнэлүүлж бэлгийн мөлжлөгт өртүүлэх, садар самуун сурталчилгаа, үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;
3. Хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх үйл ажиллагаанд оролцуулах, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;
4. Ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлууд орно.

Дээрх 1-3-т дурдсан үйл ажиллагааны 4-т тусгагдсан аюултай ажлаас бусад хүүхдийн тэвчишгүй хэлбэрүүд буюу “хүүхдийн хөдөлмөрийн үл тэвчих хэлбэрүүд” гэж нэрлэдэг. Олон улсад хүүхдийн хөдөлмөрийн үл тэвчих хэлбэрийн статистикийн ойлголт, тодорхойлолт хараахан боловсруулагдаагүй байна. Иймд энэхүү судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг аюултай ажлын хүрээнд, үндэсний хууль тогтоомжтой уялдуулан холбогдох мэдээлэл цуглуулсан.

Судалгаагаар хүүхдийн хөдөлмөрт оролцож буй таван хүүхэд тутмын хоёр нь эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахууны хөгжилд шууд нөлөө үзүүлэх аюултай ажилд оролцсон байна.


Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдэд хүүхдийн аюултай ажилд оролцож байгаа хүүхдийн эзлэх хувь 6.8 хувь байна.

▶Зураг 5.22. Хүүхдийн аюултай ажилд оролцсон хувь, хүйс, насны бүлэг, байршлаар



Хүүхдийн аюултай ажилд оролцох нь охид (4.4%)-оос хөвгүүд (9.1%)-ийн дунд илүү байгаа бөгөөд хүүхдийн нас нэмэгдэх тусам хүүхдийн аюултай ажилд оролцох нь нэмэгдэж байна. Тухайлбал, 5-12 насныхны 3.5% нь аюултай ажилд оролцож байгаа бол 13-14 насныхны 11.0%, 15-17 насныхны 17.0% нь аюултай ажилд оролцсон байна. Байршлын хувьд, хөдөөд хүүхдийн аюултай ажил илүү өргөн тархсан буюу 15.4 хувьтай байна. Зураг 5.23-т харуулснаар, Бүс нутгийн хувьд ихээхэн ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, Баруун бүсийн Ховд аймагт хүүхдийн аюултай ажилд оролцох нь хамгийн их, Төвийн бүсийн Өмнөговь аймагт хамгийн бага байна. Харин Говьсүмбэр (Төвийн бүс) аймагт хүүхэд аюултай ажилд оролцоогүй байна.

▶Зураг 5.23. Хүүхдийн аюултай ажилд оролцсон хувь, аймаг, нийслэлээр



▶Зураг 5.24. Хүүхдийн аюултай ажил, аюултай байдлын хэлбэрээр




Хүүхдийн аюултай ажилд оролцсон хүүхдүүдийн дийлэнх нь буюу 49.4 мянга (84.8%) нь хөдөлмөрийн аюултай нөхцөлд, 1.7 мянга буюу 3.0 хувь нь аюултайд тооцогдох салбар, мэргэжлээр, 1.0 мянга буюу 1.8 хувь нь хэт их цагаар ажиллаж байна. Хүүхдийн аюултай ажилд оролцож буй арван хүүхэд тутмын нэг нь (6.0 мянга буюу 10.4%) нь аюултай байдлын олон хэлбэр бүхий нөхцөлд ажиллаж байна.

Судалгаагаар хүүхдийн аюултай ажилд оролцож буй нийт хүүхдийн 4.8 мянга (аюултай ажлын бусад хэлбэрүүдэд хамаарагдах буюу холимог гэж тодорхойлогдсон хүүхэд орсон дүн) буюу 8.2 хувь нь Хөдөлмөрийн сайд (хуучнаар)-ын 2016 онд баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-нд тусгагдсан ажил мэргэжлийн ажлыг хийж байна.

Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байранд ажиллаж буй таван хүүхэд тутмын хоёр нь барилгын салбарт дотоод засал, чимэглэлийн туслах, барилгын материал, багаж хэрэгсэл зөөх зэрэг барилгын ажилд туслан гүйцэтгэх ажлыг ийж байна.


► **Зураг 5.25. Хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд, салбар, мэргэжил, хүйсээр**



Хориглосон ажлын байранд хүүхдийн хөдөлмөрт оролцож буй 4.8 мянган хүүхдийн 4.2 мянга буюу 88.0 хувь нь хөвгүүд байна. Охидын хувьд барилгын салбарт дотоод засал чимэглэлийн туслан гүйцэтгэх ажил, худалдааны салбарт ачаа өргөж зөөх, буулгах ажил, шувуу, зөгий үржүүлэх аж ахуйн ажилд оролцсон болон хурдны морь унасан бол хөвгүүдийн хувьд илүү олон төрлийн ажил, мэргэжил бүхий үйл ажиллагаанд оролцсон байна.


Хориглосон ажлын байранд ажиллаж буй хүүхдүүдийн насны бүлэг болон байршлын ялгааг дараах зургаар харууллаа.

► **Зураг 5.26. Хориглосон ажлын байранд ажиллаж байгаа хүүхэд, салбар, мэргэжил, насны бүлэг, байршил, дүнд эзлэх хувиар**




Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн 3.4 хувь нь хэт их цагаар ажиллаж байгаа бол хүйсийн хувьд хөвгүүд өндөр, байршлын хувьд хөдөөд өндөр хувьтай байна. Сүүлийн долоо хоногт 30-аас их цагаар ажилласан (аюултай ажлын бусад хэлбэрүүдэд хамаарагдах буюу холимог гэж тодорхойлогдсон хүүхэд орсон дүн) 5-17 насны 4.7 мянган хүүхэд байна. Хэт их цагаар ажилласан хүүхдүүдийн 2.1 мянга буюу 45.6 хувь нь зөвхөн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцсон, 0.5 мянга буюу 11.5 хувь нь зөвхөн цалин хөлс, орлого олох ажилд оролцсон бол 2.0 мянга буюу 42.9 хувь нь эдгээр ажлыг хавсран, давхар оролцсон байна.

►Зураг 5.27. Хэт их цагаар хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд, ажлын хэлбэрээр, дүнд эзлэх хувиар




►Зураг 5.28. Хэт их цагаар хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн хувь



Аюултай ажлын байрны нөхцөлд хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн хувьд, тэдний хамгийн нийтлэг аюул нь хэт өндөр температур эсвэл чийгшил, тоос шороотой нөхцөл (27.5%) ажилласан байна. Охид том мал, тэжээвэр амьтан өсгөхтэй холбоотой аюултай нөхцөлд илүү их ажиллаж байгаа бол хөвгүүд хэт халуун, хүйтэн, чийглэг нөхцөлд илүү их ажиллаж байна. Хөдөө орон нутагт, хэт халуун эсвэл хүйтэн, чийгтэй нөхцөлд ажиллах (31%), бод мал (адуу, үхэр, тэмээ), тэжээвэр амьтдыг өсгөх (26.9%) үйл ажиллагаанд оролцох нь хамгийн их аюултай нөхцөлд тооцогдож байна. Харин хот, суурин газарт илүү олон төрлийн аюултай нөхцөлд хүүхэд ажиллаж байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, хот суурин газарт амьдарч буй хүүхдүүдийн ихэнх нь аюултай бодис, юмстай харьцах үйл явцад оролцсон, гэрэл муутай, эсвэл хэт их гэрэлтэй орчинд ажилласан, эсвэл хэт халуун, хүйтэн, чийгтэй нөхцөлд ажилласан (тус бүх 18%-аас дээш) байна.

► **Зураг 5.29. Ажлын байрны аюултай нөхцөлд хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхэд, ажлын нөхцөлөөр**



5.6. Хүүхдийн хөдөлмөрийн улирлын хэлбэлзэл


Хүүхдийн хөдөлмөр улирлаар хэрхэн хэлбэлзэл байгааг тодорхойлох зорилгоор судалгааны түүврийн хэмжээг дөрвөн улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хийсэн.

Судалгаагаар хүүхдийн хөдөлмөр улирлаар хэлбэлзэж байгаа бөгөөд 3 дугаар улирал (7-9 сар)-д хамгийн их буюу 158.5 мянган (18.6%) хүүхэд, 4 дүгээр улирал (10-12 сар)-д хамгийн бага буюу 90.1 мянган (10.6%) хүүхэд хүүхдийн хөдөлмөрт оролцсон байна. Энэ нь 4 дүгээр улиралд ил задгай газар эсвэл гадаа ажиллахад тохиромжгүй хамгийн хүйтэн, хатуу ширүүн уур амьсгалтай байдаг учраас хүүхдүүд хүүхдийн хөдөлмөрт оролцох нь бага байж болох талтай юм. Харин 3 дугаар улиралд хүүхдийн хөдөлмөрийн түвшин хамгийн өндөр байгаа нь сурагчдын зуны амралтын үе таарч, зуны улиралд хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдогтой холбоотой байж болох юм.


▶ Хүснэгт 5.6. Хүүхдийн хөдөлмөр, улирал, хүйс, насны бүлэг, байршлаар

Үзүүлэлт	1-р улирал		2-р улирал		3-р улирал		4-р улирал		
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
Бүгд	108 431	100.0	141 881	100.0	158 464	100.0	90 105	100.0	
Хүйс	Хөвгүүд	68 567	63.2	89 580	63.1	100 040	63.1	56 205	62.4
	Охид	39 864	36.8	52 301	36.9	58 424	36.9	33 900	37.6
	5 - 12 нас	80 760	74.5	108 555	76.5	111 912	70.6	61 596	68.4
Насны бүлэг	13 - 14 нас	9 823	9.1	12 955	9.1	18 939	12.0	10 726	11.9
	15 - 17 нас	17 848	16.5	20 371	14.4	27 613	17.4	17 783	19.7
Байршил	Хот	64 544	59.5	88 960	62.7	81 715	51.6	48 296	53.6
	Хөдөө	43 887	40.5	52 921	37.3	76 749	48.4	41 809	46.4


▶ Зураг 5.30. Хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн аюултай ажилд оролцсон хувь, улирлаар



▶ Зураг 5.31. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, хүйс, улирлаар



► **Зураг 5.32. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, байршил, улирлаар**




Хөдөө орон нутагт хүүхдийн хөдөлмөрийн улирлын хэлбэлзэл нь хот суурин газрынхаас илүү их ажиглагдаж байна. Хот суурин газарт, 4 дүгээр улиралд хүүхдийн хөдөлмөрийн түвшин хамгийн бага буюу 7.2%, 2 дугаар улиралд хамгийн их буюу 13.2% хүрч буурсан байна. Энэ нь өрхийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл ус авах, түлээ, түлш бэлтгэх үйл ажиллагаанд оролцох нь буурсантай холбоотой байна. Хөдөө орон нутагт хүүхдийн хөдөлмөр, 3 дугаар улиралд хамгийн өндөр буюу 44.8% байгаа бол

4 дүгээр улиралд хамгийн бага буюу 23.6% байна.

Монгол орны жилийн дөрвөн улирлын онцлогоос шалтгаалан хүүхдийн хөдөлмөр эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар ялгаатай байгаа нь дараах зургаас харагдаж байна.


► **Зураг 5.33. Хүүхдийн хөдөлмөр, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, мянган хүүхдээр**



Судалгааны дүнгээс харахад бүх улирлуудад нийт хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхдүүдэд ус зөөх, түлээ бэлтгэх, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх


хувь өндөр байна. Энэ нь Монгол орны онцлог шинж байдал буюу монголчуудын эрт дээр үеэс таван хошуу малыг жилийн дөрвөн улиралд маллан, өсгөн, үржүүлж ирсэн уламжлалт ахуйтай холбоотой.


▶ **Зураг 5.34. Хүүхдийн хөдөлмөр, ажлын хэлбэр, улирлаар, мянган хүүхдээр**



Хүүхдүүд өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлд оролцох оролцоо 1-ээс 3 дугаар улиралд өсөж байгаа ч үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төрлөөр авч үзэхэд, болох ус зөөх, түлээ бэлтгэх ажилд оролцсон хүүхэд 1-ээс 2 дугаар улиралд өсөж, 3 дугаар улирлаас буурсан (Зураг 5.34) байна. Энэ нь байгалийн цаг уур, улирлын шинж байдалтай холбоотой.

▶ **Зураг 5.35. Хүүхдийн хөдөлмөр, ангилал, улирлаар, мянган хүүхдээр**





ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТ
ОРОЛЦОЖ БУЙ ХҮҮХЭД,
ТЭДНИЙ ӨРХИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ,
СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ



Энэ бүлэгт хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдүүдийн амьдарч буй өрхийн нийгэм, эдийн засгийн байдал, өрхийн бүтцийг судлан, эдгээд шинж чанар болон хүүхдийн хөдөлмөр хоорондын хамаарлыг тогтоох, тодорхойлохыг зорьсон. Ингэснээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх бодлогын тэргүүлэх зорилтот бүлэг, тэдэнд чиглүүлэх онцлог шинжүүдийг тодорхойлоход ач холбогдолтой. Мөн энэ хэсэгт хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн сургуульд хамрагдалтын талаар авч үзсэн.

6.1. Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал

Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй арван хүүхэд тутмын хоёр нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд, мөн хоёр хүүхдийн нэг нь 5-6 ам бүлтэй өрхөд амьдарч байна.

► Хүснэгт 6.1. Хүүхдийн хөдөлмөр, өрхийн тэргүүлэгчийн хүйс, ам бүлийн тоогоор

Байршил, бүс, аймаг	Өрхийн тэргүүлэгчээр		Ам бүлийн тоо					Бүгд
	Эрэгтэй	Эмэгтэй	< 3	3 - 4	5 - 6	7 - 8	9 +	
Хот	45 018	15 726	2 632	19 879	30 200	7 061	972	60 744
Хөдөө	70 672	7 109	1 366	16 433	46 304	12 009	1 669	77 781
Баруун бүс	37 097	3 422	447	7 356	22 954	8 302	1 460	40 519
Хангайн бүс	25 053	4 037	1 292	7 556	16 739	3 200	303	29 090
Төвийн бүс	14 913	2 726	402	4 320	11 315	1 411	191	17 639
Зүүн бүс	9 486	2 124	579	3 665	5 874	1 276	216	11 610
Улаанбаатар	29 141	10 526	1 278	13 415	19 622	4 881	471	39 667
Бүгд	115 690	22 835	3 998	36 312	76 504	19 070	2 641	138 525

► Зураг 6.1. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, өрхийн тэргүүлэгч, ам бүлээр




Хүүхдийн хөдөлмөрийн түвшин буюу 5-17 насны нийт хүүхдэд хүүхдийн хөдөлмөрт оролцсон хүүхдийн эзлэх хувь 3-4 ам бүлтэй өрхийн хувьд хамгийн бага буюу 12.7% байгаа бол 7-8 ам бүлтэй (21.4%), 3-аас доош ам бүлтэй (17.6%) өрхийн болон ганц бие өрх толгойлсон эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хүүхдийн хөдөлмөрийн түвшин хамгийн өндөр байна. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд 14.1 хувь, эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд 16.8 хувь байна.

Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр авч үзэхэд, өрхийн тэргүүний боловсролын түвшин өндөр байх тусам хүүхдийн хөдөлмөр бага байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдаж байна. Өрхийн тэргүүлэгч нь боловсрол эзэмшээгүй өрхийн дунд хүүхдийн хөдөлмөр 33.2% байгаа бол өрхийн тэргүүлэгч нь дээд боловсролтын өрхөд 10.2% болж буурч байна.


Өрхийн усан хангамжийн хувьд, төвлөрсөн усан хангамжтай өрхийн хүүхдийн хөдөлмөр хамгийн бага буюу 1.4% байгаа бол бусад төрлийн усан хангамжтай өрхийн хувьд хүүхдийн хөдөлмөр нэмэгдэж байна. Тухайлбал, усны эх үүсвэр нь ус түгээх цэг бүхий өрхийн хувьд 17.0%, булаг, шандын эх үүсвэр бүхий өрхийн хувьд 49.4% байна. Мөн өрхийн сууцны төрлөөр, орон сууцны

байшинд эсвэл бие даасан тохилог сууцад амьдардаг өрхийн хүүхдүүдийн хөдөлмөр 1.3-2.0 хувь байгаа бол зориулалтын бус сууц (амбаар, овоохой, агуулах, вагон бүхий битүү чиргүүл гэх мэт)-д болон гэрт амьдарч буй хүүхдийн хувьд 25 хувиас дээш байна.

► **Зураг 6.2. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин, аав, ээжтэйгээ амьдардаг эсэхээр**



► **Зураг 6.3. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, өрхийн сууц, усан хангамжийн төрлөөр**



Өрхийн сарын дундаж орлогын хувьд, сард 200-400 мянган төгрөгийн орлоготой өрхөд амьдарч буй хүүхдийн дунд хүүхдийн хөдөлмөрийн түвшин 28.0% болж өсөж, 400-600 мянган төгрөгийн орлоготой өрхийн хувьд 25.1%, 600-1400.0 төгрөгийн орлоготой өрхийн хувьд 17.3%, 1400 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхийн хувьд 9.1% болж буурч байна.

Сүүлийн 12 сарын хугацаанд өрхийн орлого нь буурсан өрхийн хүүхдийн хөдөлмөрийн түвшин 17.8 хувь, орлого нь буураагүй өрхийн хүүхдийн хөдөлмөрийн түвшин 15.9 хувь байна. Судалгаагаар өрхийн орлого буурахад нөлөөлсөн хүчин зүйлийг тодруулж асуусан бөгөөд байгалийн хүчин зүйлээс үүдэн хямрал үүссэн өрхийн хүүхдүүдийн 23.4 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцсон бол нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үүдэн хямрал үүссэн өрхийн хүүхдүүдийн 21.0 хувь, өрхийн аль нэг гишүүн нь өвдсөн өрхийн хүүхдүүдийн 12.1 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцсон байна. Өрхийн гишүүд нь өвдсөн өрхийн дунд хүүхдийн хөдөлмөрийн тархалт эдийн засгийн болон байгалийн хүчин зүйлийн хямралд өртсөн өрхтэй харьцуулахад бага байгаа нь өөрийн эцсийн үйлчилгээний буюу өвчтэй өрхийн гишүүнээ асран халамжлах болон гэрийн ажил (үйлчилгээ)-д илүү оролцож байгаатай холбоотой байж болно.

▶ **Зураг 6.4. Хүүхдийн хөдөлмөрийн түвшин, өрхийн сарын дундаж орлогоор, хямралд өртсөн өрх эсэхээр**



6.2. Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн сургуульд хамрагдалт


Энэ хэсэгт хүүхдийн сургуульд хамрагдалтыг Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 “Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй” гэж заасны дагуу 6-14 насны хүүхдийг онцлон авч үзсэн.

Судалгаагаар 6-14 настай хүүхдүүдийн 96.6 хувь нь сургуульд хамрагдсан, 3.4 хувь нь сургуульд хамрагдаагүй байна. Насаар авч үзэхэд, 6 настай хүүхдүүдийн сургууль хамрагдалт нэлээн бага байгаа нь судалгаанд хамрагдсан хүүхдүүд судалгаа авах тухайн хугацаанд 6 нас хүрсэн ч хичээлийн шинэ жил эхлээгүй байсантай холбоотой байж болох юм. Нөгөөтээгүүр Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллээр, нэгдүгээр ангид элсэгчдийн цэвэр жин 2020 онд 97.0 хувь, 2021 онд 94.7 хувь, 2022 онд 91.6 хувь болж буурсан байна. Энэ нь сүүлийн жилүүдэд үүссэн цар тахлын улмаас эцэг, эхчүүд хүүхдээ сургуульд хамруулах, цахимаар сургах нь буурсантай холбоотой.


Хүүхдийн хөдөлмөр болон хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын хамаарлыг харахад, тийм ч их ялгаа ажиглагдахгүй байгаа ба хүйсийн хувьд мөн адил байна. Гэхдээ, 8 хүртэлх насны охидын хувьд, хэрэв хүүхдийн хөдөлмөрт оролцоогүй бол сургуульд суралцах магадлалтай байна.

6-14 насны хүүхдүүдийн 111.6 мянга буюу 17.3 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцсон, тэдгээр хүүхдийн сургуульд хамрагдалт 96.7 хувь байна.

► **Зураг 6.5. Сургуульд хамрагдалтын хувь, хүүхдийн хөдөлмөрт хамрагдалтаар, насаар**




► **Зураг 6.6. Сургуульд хамрагдалтын хувь, хүйс, насаар**



Хүүхдийн хөдөлмөрт оролцож буй 6-14 насны хүүхдийн 1.5 мянга буюу 1.3 хувь нь өмнөх хичээлийн жилд суралцаагүй байна. Эдгээр суралцаагүй хүүхдүүдийн шалтгааныг тодруулахад таван хүүхэд тутмын гурав нь сургууль хол, арван хүүхэд тутмын нэг нь мал маллахаар гэж хариулсан байна.

▶ **Зураг 6.7. Өмнөх хичээлийн жилд суралцаагүй шалтгаан**





ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ
ХАНДЛАГА, ХҮҮХДИЙН
ХӨДӨЛМӨРТ НӨЛӨӨЛӨХ
ХҮЧИН ЗҮЙЛИЙН
ШИНЖИЛГЭЭ




7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааны чиг хандлага

Энэ удаагийн ХХС нь өмнөх онуудын судалгаануудтай харьцуулахад шинэ аргачлал, ойлголт, тодорхойлолт ашигласан тул мэдээллийн харьцуулахуйц байх чанар алдагдаж, хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр нөлөөнд дүгнэлт өгөх боломжгүйд хүрсэн. Иймээс тоон мэдээллийн хугацааны цуваанаас хамаараад дараагийн дэд бүлэгт хүүхдийн хөдөлмөрийн чиг хандлагыг тусгалгүй, зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн хандлагыг авч үзсэн.


5-17 насны хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо 2002-2003 онд 10.1 байсан бол 2011-2012 онд 16.0 хувь, 2021-2022 онд 24.4 хувь болж өссөн байна. Уг өсөлтийг насны бүлгээр авч үзэхэд, 10-17 насанд өндөр өссөн нь нөлөөлжээ. Тухайлбал, өмнөх онуудад 10-14 насанд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо 7.3-18.0 хувьтай байсан бол энэ удаагийн судалгаагаар 32.2 хувь, 15-17 насанд 16.1-22.3 хувь байсан бол 43.5 хувь болж өссөн байна.

Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдсэн нь судалгааны арга зүй, хүүхдийн ажлын хүрээг хэмжих аргачлалын өөрчлөлтөөс шалтгаалсан байж болзошгүйг анхаарч үзэх нь зүйтэй. Түүнчлэн, хүн ам зүйн чиг хандлага, хөдөөгөөс хот руу шилжих шилжилт хөдөлгөөн уг өсөлтөд нөлөөлсөн байж болзошгүй, учир нь хот суурин газарт шилжин ирэгсэд ихээхэн эмзэг байдаг.

► Зураг 7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, нийт хүүхдэд эзлэх хувь, судалгаа явуулсан оноор



► Зураг 7.2. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, судалгаа явуулсан оноор



Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон нийт хүүхдийг насны бүлгээр дүнд эзлэх хувиар нь авч үзэхэд, 5-9 настай хүүхдийн эзлэх хувь бага хэлбэлзсэн бол 10-14 насныхан буурч, 15-17 насныхан өссөн байна.

► Хүснэгт 7.1. Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа, судалгаа явуулсан оноор

Үзүүлэлт	2002-2003	2006-2007	2011-2012	2021-2022	
Бүгд	Бүгд	68 580	71 330	93 968	207 951
	5-9	15 320	18 116	17 677	41 918
	10-14	21 407	25 016	42 569	105 932
	15-17	31 853	28 198	33 722	60 101
Хөвгүүд	Бүгд	41 874	43 037	50 870	126 141
	5-9	9 005	10 332	9 648	25 425
	10-14	13 762	14 929	22 653	63 350
	15-17	19 107	17 776	18 569	37 366
Охид	Бүгд	26 706	28 293	43 098	81 810
	5-9	6 315	7 784	8 029	16 493
	10-14	7 645	10 087	19 916	42 582
	15-17	12 746	10 422	15 153	22 735

7.2. Хүүхдийн хөдөлмөрт нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ

Энэ хэсэгт хүүхдийн хөдөлмөр, аюултай хөдөлмөрт нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээг хийж хүүхдийн хөдөлмөрт нөлөөлөх өрхийн болон хувь хүний хүчин зүйлийг тодорхойлохыг зорьсон. Хүүхдийн хөдөлмөрт эдийн засаг, нийгмийн өргөн хүрээтэй макро хүчин зүйлүүд нөлөөлөх боловч түүнээс илүүтэй тухайн гэр бүлийн орчин дах микро хүчин зүйлс хүүхдийн хөдөлмөрт ихээхэн нөлөөлдөг. Хүүхдийн хөдөлмөрийг бууруулах бодлого, хөтөлбөр боловсруулахад хүүхдийн хөдөлмөрт нөлөөлж буй макро болон микро хүчин зүйлсийг оновчтой тодорхойлох нь чухал үүрэгтэй.

Энэ хэсэгт Стэпвайс ложистик регрессийн шинжилгээний арга зүйг ашиглаж хүүхдийн хөдөлмөрийн микро хүчин зүйлийн нөлөөллийг тооцсон. Стэпвайс ложистик регрессийн арга нь сайн гүйцэтгэлтэй загвар гаргахын тулд хамааран хувьсагч болон үл хамааран хувьсагчдын хоорондын хамаарлыг шалгах замаар үл хамааран хувьсагчдыг алхам алхмаар цөөлдөг давталттай арга юм

Хүүхдийн хөдөлмөр нь хамааран хувьсагч бөгөөд өрхийн амьжиргаа, сууцны нөхцөл, өрхийн тэргүүлэгчийн болон хүүхдийн хувь хүний хүчин зүйлсийг тайлбарлагч хувьсагчаар сонгож загварт ашигласан. Хүүхдийн хөдөлмөрт нөлөөлж буй тайлбарлагч хувьсагчдыг сонгохдоо өмнөх судалгаа шинжилгээний үр дүн болон практикаар хүүхдийн хөдөлмөрт нөлөөлдөг гэж үздэг хүчин зүйлсийг сонгосон.

▶ Хүснэгт 7.2. Ложистик регрессийн шинжилгээнд ашигласан хувьсагч, түүний тайлбар

№	Хувьсагч	Тайлбар	Төрөл
1	childlab	ОУХБ-ын аргачлалаар тодорхойлсон 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхэлдэг эсэх (Хүүхдийн хөдөлмөр эрхэлдэг бол 1, эрхэлдэггүй бол 0)	Дамми
2	age	Хүүхдийн бүтэн нас	Тоо
3	age2	Хүүхдийн бүтэн насны квадрат	Тоо
4	male	Хүүхдийн хүйс (Эрэгтэй бол 1, эмэгтэй бол 0)	Дамми
5	rural	Хүүхдийн суурьшил (Хөдөө бол 1, хот бол 0)	Дамми
6	dwell	Хүүхдийн амьдардаг сууцны төрөл (гэр, сууцны тусдаа байшин, нийтийн байр, бусад сууцад амьдардаг бол 1, бие даасан тохилог сууц, орон сууцад амьдардаг бол 0)	Дамми
7	loan	Хүүхдийн амьдардаг өрх зээлтэй эсэх (Зээлтэй бол 1, зээлгүй бол 0)	Дамми
8	disab	Хүүхэд хөдөлмөрийн бэрхшээлтэй эсэх (Хөгжлийн бэрхшээлтэй бол 1, хөгжлийн бэрхшээлгүй бол 0)	Дамми
9	hhhead_gender	Өрхийн тэргүүлэгчийн хүйс эмэгтэй бол 1, эрэгтэй бол 0	Дамми
10	head_edu_high	Өрхийн тэргүүлэгчийн боловсролд түвшин дипломын дээд болон түүнээс дээш бол 1, доош бол 0	Дамми
11	withparents	Эцэг, эхтэйгээ хоёртойгоо нь амьдардаг эсэх (Хоёулантай нь амьдардаг бол 1, аль нэгэнтэй болон алинтайн ч амьдардаггүй бол 0)	Дамми
12	hsize	Өрхийн хамт амьдардаг ам бүлийн тоо	Тоо
13	sifund	Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн өрхөөс аль нэг хүн нь Нийгмийн даатгалын сангаас орлого олсон эсэх (олсон бол 1 олоогүй бол 0)	Дамми
14	swfund	Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн өрхөөс аль нэг хүн нь Нийгмийн халамжийн сангаас хүүхдийн мөнгөнөөс бусад орлого олсон эсэх (олсон бол 1 олоогүй бол 0)	Дамми
15	lsfund	Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн өрхөөс аль нэг хүн нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас орлого олсон эсэх (олсон бол 1 олоогүй бол 0)	Дамми
16	dec_inc	Сүүлийн 12 сард тухайн өрхийн орлого буурсан эсэх (буурсан бол 1, Дамми өссөн болон өөрчлөгдөөгүй бол 0)	Дамми
17	quarter1	1 дүгээр улирал эсэх (1 дүгээр улирал бол 1, бусад улирал бол 0)	Дамми
18	quarter2	2 дугаар улирал эсэх (2 дугаар улирал бол 1, бусад улирал бол 0)	Дамми
19	Quarter3	3 дугаар улирал эсэх (3 дугаар улирал бол 1, бусад улирал бол 0)	Дамми
20	Income1	Өрхийн орлогын тэнцүү таван бүлгийн 1 дүгээр хэсэгт багтсан эсэх (Багтсан бол 1, бусад бол 0)	Дамми
21	Income2	Өрхийн орлогын тэнцүү таван бүлгийн 2 дугаар хэсэгт багтсан эсэх (Багтсан бол 1, бусад бол 0)	Дамми
22	Income3	Өрхийн орлогын тэнцүү таван бүлгийн 3 дугаар хэсэгт багтсан эсэх (Багтсан бол 1, бусад бол 0)	Дамми
23	Income4	Өрхийн орлогын тэнцүү таван бүлгийн 4 дүгээр хэсэгт багтсан эсэх (Багтсан бол 1, бусад бол 0)	Дамми

Хүүхдийн хөдөлмөрт нөлөөлсөн хүчин зүйлийг дээрх хувьсагчдаар үнэлэхэд хүүхдийн хөдөлмөрт хүүхдийн нас нэмэгдэх (нас нэмэгдэхэд ахиу хандлага буурах), эрэгтэй, хөдөө амьдардаг, гэр, сууцны тусдаа байшин, нийтийн байр, бусад сууцад амьдардаг, хүүхдийн өрх нь зээлтэй, өрхийн аль нэг гишүүн нь сүүлийн 12 сард хүүхдийн мөнгөнөөс бусад халамжийн орлого олсон, сүүлийн 12 сард өрхийн орлого буурсан зэрэг хүчин зүйлс нь хүүхдийн хөдөлмөрийг нэмэгдүүлж байна. Бусад сонгож авсан тайлбарлагч хувьсагчдын хувьд хүүхдийн хөдөлмөрт статистик ач холбогдол бүхий нөлөөгүй байна.

► **Хүснэгт 7.3. Хүүхдийн хөдөлмөрт нөлөөлсөн хүчин зүйлсийн стэпвайс ложистик регрессийн шинжилгээний маржинал эффект**

Тайлбарлагч хувьсагч	Маржинал эффект	Стандарт алдаа	z	P утга	95 хувийн итгэх интервал	
					Доод	Дээд
age	0.109	0.006	19.48	0.000	0.098	age
age2	-0.005	0.000	-17.50	0.000	-0.005	age2
male	0.071	0.005	13.56	0.000	0.061	male
rural	0.096	0.006	17.09	0.000	0.085	rural
dwel	0.298	0.015	19.68	0.000	0.269	dwel
loan	0.010	0.006	1.73	0.084	-0.001	loan
income4	-0.028	0.008	-3.60	0.000	-0.043	income4
quarter2	0.071	0.009	8.34	0.000	0.054	quarter2
quarter3	0.119	0.008	15.15	0.000	0.104	quarter3
swfund	0.028	0.005	5.14	0.000	0.017	swfund
quarter1	0.024	0.009	2.70	0.007	0.007	quarter1
dec_inc	0.036	0.007	5.05	0.000	0.022	dec_inc

Дээр дурдсан хувьсагч болон хүүхдийн аюултай ажлын хоорондын хамаарлыг Стэпвайс ложистик регрессийн шинжилгээгээр шинжилж үзэхэд ихэнх хувьсагчид ижил байгаа боловч статистик ач холбогдолтой зарим хувьсагчид нэмэгдсэн байна. Тодруулбал, хүүхдийн аюултай ажлыг буруулах магадлалтай хувьсагч нэмэгдсэн байна.

Тухайн хүүхдийн амьдарч буй өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй, тухайн өрх нь нийгмийн даатгалын сангаас сүүлийн 12 сард орлого олсон байх нь хүүхдийн аюултай ажлыг бууруулагч хүчин зүйл болж байна. Бусад хүчин зүйлийн хувьд хүүхдийн хөдөлмөрт нөлөөлсөн хүчин зүйлтэй ижил хандлагатай байна. Бусад сонгож авсан тайлбарлагч хувьсагчдын хувьд хүүхдийн аюултай ажилдыг статистик ач холбогдол бүхий нөлөөгүй байна.

► **Хүснэгт 7.4. Хүүхдийн аюултай ажилд нөлөөлсөн хүчин зүйлсийн стэпвайс ложистик регрессийн шинжилгээний маржинал эффект**

Тайлбарлагч хувьсагч	Маржинал эффект	Стандарт алдаа	z	P утга	95 хувийн итгэх интервал	
					Доод	Дээд
age	0.033	0.004	7.96	0.000	0.025	age
age2	-0.001	0.000	-4.52	0.000	-0.001	age2
male	0.045	0.004	11.97	0.000	0.038	male
rural	0.069	0.004	16.59	0.000	0.061	rural
Dwell	0.106	0.010	10.18	0.000	0.086	Dwell
loan	0.012	0.004	3.10	0.002	0.005	loan
hhhead_gender	-0.014	0.008	-1.89	0.059	-0.029	hhhead_gender
income4	-0.012	0.006	-2.01	0.045	-0.023	income4
withparents	-0.012	0.007	-1.68	0.093	-0.025	withparents
sifund	-0.010	0.005	-2.14	0.032	-0.019	sifund

Тайлбарлагч хувьсагч	Маржинал эффект	Стандарт алдаа	z	P утга	95 хувийн итгэх интервал	
					Доод	Дээд
swfund	0.020	0.004	5.36	0.000	0.012	swfund
quarter3	0.051	0.004	12.53	0.000	0.043	quarter3
income1	0.015	0.004	3.64	0.000	0.007	income1
dec_inc	0.033	0.005	6.96	0.000	0.023	dec_inc
quarter2	0.019	0.005	4.16	0.000	0.010	quarter2

Шинжилгээний үр дүн дараах байдлаар тайлбарлагдаж байна. Үүнд:

1. Хүүхдийн хөдөлмөр нэмэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс:

- ▶ Хүүхдийн нас нэмэгдэх нь тэдний хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлалыг нэмэгдүүлдэг боловч нас нэмэгдэх тусам хүүхдийн хөдөлмөрт оролцох ахиу хандлага буурдаг.
- ▶ Эрэгтэй хүүхэд эмэгтэй хүүхдээс илүү хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлал өндөр.
- ▶ Хөдөө амьдарч байгаа хүүхэд хотод амьдарч байгаа хүүхдээс илүү хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлал өндөр.
- ▶ Гэр, сууцны тусдаа байшин, нийтийн байр, бусад сууцад амьдардаг хүүхэд, бие даасан тохилог сууц, орон сууцад амьдардаг хүүхэд хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлал өндөр.
- ▶ Зээлтэй өрхөд амьдарч байгаа хүүхэд зээлгүй өрхөд амьдарч буй хүүхдээс илүү хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлал өндөр.
- ▶ Сүүлийн 12 сард хүүхдийн мөнгөнөөс бусад нийгмийн даатгалын сангаас орлого олсон өрхөд амьдарч буй хүүхэд, тус орлогыг олоогүй өрхөд амьдарч байгаа хүүхдээс хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлал өндөр байна. Энэ нь хүлээн авсан мөнгө нь өрхийн хэрэгцээг хангахад хүрэлцээгүй байгаагийн илэрхийлэл байж болох юм.
- ▶ Сүүлийн 12 сард өрхийн орлого буурсан гэж мэдэгдсэн өрхөд амьдарч буй хүүхэд, орлого өссөн, өөрчлөгдөөгүй гэж хариулсан өрхөд амьдарч байгаа хүүхдээс хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлал өндөр байна.

2. Хүүхдийн хөдөлмөрийг бууруулахад нөлөөлж буй хүчин зүйл.


- ▶ Өрхийн орлогын тэнцүү таван бүлэг хуваасны 4 дүгээр өндөр орлоготой өрхөд амьдарч буй хүүхэд, бусад бүлэгт амьдарч буй хүүхдээс хүүхдийн хөдөлмөрт оролцох магадлал бага байна.

3. Хүүхдийн аюултай ажлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйл.

- ▶ Хүүхдийн аюултай ажлыг нэмэгдүүлэгч хүчин зүйлс нь хүүхдийн хөдөлмөрт нөлөөлж буй хүчин зүйлтэй ижил хандлагатай байна.

4. Хүүхдийн аюултай ажлыг бууруулахад нөлөөлж буй хүчин зүйл.

- ▶ Тухайн хүүхдийн амьдарч буй өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй бол эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд амьдарч буй хүүхдээс аюултай ажилд оролцох магадлал бага.
- ▶ Сүүлийн 12 сард нийгмийн даатгалын сангаас орлого олсон өрхөд амьдарч байгаа хүүхэд, тус сангаас орлого олоогүй өрхөд амьдарч байгаа хүүхдээс аюултай ажилд оролцох магадлал бага байна.



ХҮҮХДИЙН ГЭРИЙН АЖИЛ, ЧӨЛӨӨТ ЦАГ




Энэ бүлэгт хүүхдийн өөрийн гэрийн ажилд хэрхэн оролцсон талаар судалсан болно. Гэрийн ажил гэдгийг өөрийн эцсийн хэрэглээний үйлчилгээний ажлын хүрээнд тодорхойлсон. Гэрийн ажил нь ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнээс гадуур байдаг боловч үйлдвэрлэлийн ерөнхий хүрээнд багтана.

8.1. Гэрийн ажлын оролцоо

Улсын хэмжээнд 5-17 насны нийт хүүхдийн 618.0 мянга буюу 72.5 хувь нь гэрийн ажилд оролцсон байна. Хүйсийн хувьд ялгаа өндөр буюу охидын оролцоо, хөвгүүдийнхээс 7.5 нэгж хувиар илүү байгаа бол байршлын хувьд ялгаа ажиглагдахгүй байна. Харин бүсээр авч үзэхэд зарим ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, Баруун бүсэд 74.5 хувь, Хангайн бүсэд 76.0 хувь, Төвийн бүсэд 69.3 хувь, Зүүн бүсэд 68.3 хувь, Улаанбаатарт 72.2 хувь байна.

▶ **Зураг 8.1. Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, нийт хүүхдэд эзлэх хувиар**



Гэрийн зарим ажил нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг тул аюултай байж болзошгүй гэр орны ажилд оролцож байгаа хүүхдийн мэдээллийг энэ хэсэгт тусгасан. Ингэхдээ дараах шалгуурын дагуу тооцоолсон. Үүнд:

- ▶ 5-14 насны хүүхэд гэрийн ажилд долоо хоногт 21 болон түүнээс дээш цагийг зарцуулах. Хүүхэд гэрийн ажилд хэт их цагаар оролцох нь тухайн хүүхдийн сургуульд явах, гэрийн даалгавраа хийх, сурч боловсрох боломж нь хязгаарлагдаж, сөргөөр нөлөөлнө гэж үздэг.
- ▶ 5-17 насны хүүхэд хоол хийхдээ хурц эртэй хутга, мэс ашиглах, хувцсаа индүүдэх гэх мэт нөхцөл байдлаас хамаарч аюултай байж болзошгүй гэрийн ажилд оролцож байгаагаар тооцсон.

▶ **Хүснэгт 8.1. Гэрийн ажилд оролцсон, аюултай байж болзошгүй гэрийн ажилд оролцсон хүүхэд, хүйс, насны бүлэг, байршлаар**

Үзүүлэлт	Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд			Аюултай байж болзошгүй гэрийн ажил эрхэлсэн хүүхэд		
	Бүгд	Хөвгүүд	Охид	Бүгд	Хөвгүүд	Охид
Бүгд	617 998	300 584	317 414	316 943	138 942	178 001
5 - 12 нас	378 163	181 205	196 958	130 504	54 513	75 991
13 - 14 нас	113 419	56 504	56 915	82 822	37 365	45 457
15 - 17 нас	126 416	62 875	63 541	103 617	47 064	56 553
Хот	428 651	209 153	219 498	210 866	94 407	116 459
Хөдөө	189 347	91 431	97 916	106 077	44 535	61 542

Гэрийн ажилд оролцож буй 5-17 насны хүүхдүүдийн хувийн жинг буюу тухайн насны нийт хүүхдэд эзлэх хувийг оролцсон үйл ажиллагаа тус бүрээр нь дараах зурагт харуулав. 5-17 насны таван хүүхэд тутмын бараг дөрөв нь гэрээ цэвэрлэж, сав суулга угаасан, таван хүүхэд тутмын гурав


нь гэрийнхэндээ зориулж хоол унд хийж, хийхэд нь бэлтгэн, тусалсан байна. Хүйсийн хувьд, гэрийнхэндээ зориулж хоол унд хийх, бэлтгэх, туслах, гэрийнхнийхээ хувцсыг угаах, угаалгын ажилд туслах, гэрээ цэвэрлэх, сав суулга угаах үйл ажиллагаанд охид хөвгүүдээс илүү оролцсон байна.

► **Зураг 8.2. Гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, үйл ажиллаг, хүйсээр, хувиар**



Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 37.4 хувь нь аюултай нөхцөлд гэрийн ажил хийсэн бол 5-14 насны нийт хүүхдийн 37.4 хувь нь хэт их цагаар буюу долоо хоногт 21 болон түүнээс дээш цагаар гэрийн ажил хийсэн байна. Аюултай байж болзошгүй нөхцөлүүд болон хэт их цагийг харахад, хүүхдийн нас нэмэгдэх тусам ихсэж байна. Хүйс болон байршлын хувьд их ялгаа ажиглагдахгүй байна. Охидын хувьд болон хөдөө амьдарч буй хүүхдүүдийн хувьд аюултай байж болзошгүй өөрийн эцсийн хэрэглээний үйлчилгээ бүхий гэрийн ажилд оролцох нь их байна.

► **Зураг 8.3. Хүүхдийн аюултай байж болзошгүй гэрийн ажил эрхлэлтийн түвшин, хүйс, нас, байршлаар**



Зураг 8.4-т ОУХБ-ын зөвлөмжийн дагуу нөхцөл байдлын хувьд аюултайд тооцогдох гэрийн ажил дахь хүүхдийн оролцоог харуулав.

▶ **Зураг 8.4. Аюултай нөхцөлд гэрийн ажил эрхэлсэн хүүхэд, нийт гэрийн ажил эрхэлсэн хүүхдэд эзлэх хувиар, ажлын төрлөөр**



Хүүхдүүд гэрийн ажилд долоо хоногт дунджаар 14 цаг зарцуулж байна. Гэрийн ажилд охидын оролцоо их байгаа ба тэдний долоо хоногт зарцуулсан дундаж цаг нь 13 цаг байгаа нь хөвгүүдийнхээс 2 цагаар илүү байна. Хийсэн үйл ажиллагааны төрлөөр авч үзэхэд, дүү, хөгшид, гэр бүлийн аль нэгэн өвчтэй байгаа гишүүн зэрэг гэр бүлийн гишүүдийг асрах ажилд хамгийн их цагийг зарцуулсан (долоо хоногт дунджаар 8 цаг) бол гэр цэвэрлэх, хоол хийх ажилд аль алинд нь дунджаар 5 цаг зарцуулсан байна.

►Зураг 8.5. Гэрийн ажилд зарцуулсан дундаж цаг, үйл ажиллагаагаар



8.2. Гэрийн ажил болон хүүхдийн хөдөлмөр


Хүүхдийн гэрийн ажил дахь оролцоо болон хүүхдийн хөдөлмөрт оролцох оролцоо нь тэдний сургуульд хамрагдалтад нөлөөлөх тул энэ хэсэгт хүүхдийн хөдөлмөрт оролцож буй хүүхдийн гэрийн ажилд дахь оролцоог харуулахыг зорьсон. Учир нь хүүхэд энэ хоёр үйл ажиллагаанд оролцсоноор сурч боловсрох, гэрийн даалгавраа хийх, тоглоход зарцуулах цаг нь багасдаг.


5-17 насны 118.9 мянга (19.2%)-н хүүхэд хүүхдийн хөдөлмөр болон гэрийн ажилд хоёуланд нь оролцсон байна.

►Хүснэгт 8.2. Гэрийн ажил хийсэн хүүхэд, хүүхдийн хөдөлмөрт оролцдог эсэхээр

Үзүүлэлт	Хүүхдийн хөдөлмөрт оролдог			Хүүхдийн хөдөлмөрт оролцдоггүй		
	Бүгд	Хөвгүүд	Охид	Бүгд	Хөвгүүд	Охид
Бүгд	118 898	70 403	48 495	499 100	230 181	268 919
5 - 12 нас	83 498	47 421	36 077	294 665	133 784	160 881
13 - 14 нас	14 046	8 377	5 669	99 373	48 127	51 246
15 - 17 нас	21 354	14 605	6 749	105 062	48 270	56 792
Хот	54 441	34 550	19 891	374 210	174 603	199 607
Хөдөө	64 457	35 853	28 604	124 890	55 578	69 312

Хүйсийн хувьд, хөвгүүдийн 23.4 хувь нь хүүхдийн хөдөлмөрт оролцсон болон гэрийн ажилд хоёуланд нь оролцож байгаа нь охидынхоос 8.1 нэгж хувиар их байна. Түүнчлэн, байршлын хувьд хөдөөд гэрийн ажил хийхийн зэрэгцээ хүүхдийн хөдөлмөрт оролцох нь хүүхэд их байна.

▶ **Зураг 8.6. Гэрийн ажил хийсэн хүүхэд, хүүхдийн хөдөлмөрт оролцсон эсэхээр, дүнд эзлэх хувиар**



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТЭЙ ТЭМЦЭХ ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУД, ЗӨВЛӨМЖ



Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 10 суурь конвенцын 9-д нь нэгдсэн орж хэрэгжилт, зөвлөмжийг биелүүлэн ажиллаж байна. Тухайлбал,

- ▶ Монгол Улсын Их хурлаас 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг тус тус баталсан. Эдгээр хуулийг дагаад 54 дүрэм, журам, стандарт батлагдан, мөрдөгдөж байна.
- ▶ 2017 онд Эрүүгийн тухай хуулийн 16.10 дугаар зүйл “Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэхийг гэмт хэрэгт тооцож, хариуцлага хүлээлгэх”-ийг нэмж, шинэчлэн найруулгыг баталсан.
- ▶ 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл буюу “Хүүхдийн эрхийг зөрчих” талаар шинээр тусган баталсан. Мөн тус хуулийг 2021 онд шинэчлэн найруулж, 6.20 дугаар зүйлийг шинэчлэн 8 хэсэг 10 заалт бүхий үйлдлийг зөрчилд тооцохоор тусгасан.
- ▶ 2021 онд Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн баталж, 2022 оны 1 дүгээр сараас мөрдөж эхэлсэн. Хөдөлмөрийн тухай хуульд /шинэчилсэн найруулга/ ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны суурь зарчимд “Хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах” шинэ зохицуулалтыг тусгасан. Тухайлбал,
 - ▶ 4.1.6. “насанд хүрээгүй ажилтан” гэж энэ хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцож байгаа 18 насанд хүрээгүй хүнийг,
 - ▶ 5.1.9. хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах,
 - ▶ 43.3. Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ,
 - ▶ 76.10. Насанд хүрээгүй хүнийг ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллуулахыг хориглоно,
 - ▶ 92.10. Насанд хүрээгүй хүнийг уртын ээлжээр ажиллуулахыг хориглоно.
 - ▶ 142 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлт,
 - ▶ 143 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүний эрүүл мэндийг хамгаалах; зохицуулалт шинээр туссан.
 - ▶ Түүнчлэн, тус хуульд насанд хүрээгүй хүнтэй гуравласан хөдөлмөрийн гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалтыг нарийвчилж, 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын нөхцөл, 15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулах бүрд хүүхдийн эрхийн байцаагчаас зөвшөөрөл авах, насанд хүрээгүй хүнийг ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллуулах, уртын ээлжээр ажиллуулахыг хориглосон хүүхдэд ээлтэй эрх зүйн зохицуулалтыг хийсэн.
- ▶ 2022 оны 6 дугаар сард Үндэсний их баяр наадмын тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ баталсан. Хуулийн 10.2-т “Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдах мориныг **найм, түүнээс дээш насны хүүхэд** унах бөгөөд уралдаанч хүүхэд нь үндэсний хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан нэг жилийн ослын даатгалд даатгуулсан байна” гэж хуульчилсан.
- ▶ Стандартчилал, хэмжил зүйн газар, ЗГХА- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран 2018 онд “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандарт”-ыг шинэчлэн баталж, мөрдүүлж байна.
- ▶ НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдын дэргэдэх Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс онцгой анхаарч,

2018 онд “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоол батлагдсан.

- ▶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцын 6 дугаар зүйлийн 6.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйл, “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг үндэслэн Жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины үсэргээ, сунгаа, уралдаан зохион байгуулахыг хориглосон Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол батлагдан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- ▶ Түүнчлэн 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүүхэд хамгааллын бодлогыг баталж, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтран бизнесийн байгууллагын ажилтнуудыг “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх” сургагч багшаар анх удаа бэлтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог сайжруулах ажлыг эхлүүлсэн.

Хууль эрх зүйн орчин сайжирч, тодорхой үр дүнд хүрч байгаа хэдий ч нийгмийн хамгааллыг хүртээмжтэй болгох, нийгэмд хариуцлагатай аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэх, ажилтны цалин хөлс болон хөдөлмөрийн уян хатан, таатай нөхцөлийг бий болгох замаар хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг үргэлж дэмжих нэгдсэн ойлголт, санаачилгыг сайжруулах хэрэгтэй. Ингэхдээ, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бусад салбарын яам, агентлагуудтай хамтран дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болох юм. Үүнд:

1. Олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх

- ▶ Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хүүхдийг хөдөлмөрт оролцоход хүргэж буй нөхцөл байдлыг судлах, устгах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох.
- ▶ Хууль, эрх зүйн баримтуудыг хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч болон төр, хувийн хэвшлийн байгууллагад сурталчлан таниулах, чиглэл, заавар, зөвлөмж боловсруулж, түгээх, сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

2. Нийгмийн хамгааллыг сайжруулах

- ▶ Бүх насны иргэдийг зохистой хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, бий болсон хүчин чармайлт, боломжуудыг бүрэн ашиглах, зохистой хөдөлмөрийн талаарх ойлголт, мэдлэгийг түгээх,
- ▶ Хүүхэд нь хүүхдийн хөдөлмөрт оролцдог гэр бүл эсвэл хүүхдийг хөдөлмөрт оролцуулах өндөр эрсдэлтэй гэр бүлгийг илрүүлж, тэдний хэрэгцээг хангахуйц нийгмийн хамгаалал бүхий л арга хэмжээнд хамруулах,
- ▶ Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийг устгахад чиглэсэн санхүүжилтийг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийг устгахад чиглэсэн бодлогыг баримтлах,
- ▶ Хүүхдийн хөдөлмөрт оролцож байгаа хүүхдэд эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг, оношилгоо хийх, тэдний эрүүл мэнд, үүний дотор ёс суртахууны болон сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах ажлыг холбогдох салбарын бодлого, хөтөлбөрт тусган, хэрэгжүүлэх,
- ▶ Хүүхдийн хөдөлмөрт оролцож байгаа хүүхдийн боловсрол, хүмүүжил, төлөвшлийн асуудалд анхаарч, сургууль завсардах эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, хөдөлмөрөөс хөндийрүүлэх,
- ▶ Хүүхдийн хөдөлмөрт оролцож байгаа хүүхэд, тэдний гэр бүлд хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх хувилбарыг тодорхойлох.

- 3.** Барилга, хөдөө аж ахуй, уул уурхай, хөнгөн үйлдвэрийн салбарт хүүхдийн хөдөлмөрийг устгах талаар салбарын бодлого баримтлах
- ▶ Салбарын бодлогод хүүхдийн хөдөлмөрийг хориглох, устгах, хүүхэд хамгааллыг хангах зохицуулалтыг тусгах.
 - ▶ Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, ажилтан албан хаагч, харилцагч нарыг зөвлөмж мэдээллээр хангах.

► Хавсралт 1. Ойлголт, тодорхойлолт

№	АЖИЛ, АЖЛЫН ХЭЛБЭР	
1	Ажил	Ажил гэж аль ч нас, хүйсийн хүн амын бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх албан ёсны болон албан бус бүхий л үйл ажиллагааг ойлгоно. Ажил гэсэн ойлголтод бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхээс өөр үйлдэл (гуйлга гуйх, хулгай хийх), өөрийн биеийг арчлах (хувийн ариун цэвэр сахих, арьс арчилгаа хийх, өөрийгөө сувилах) болон тухайн хүний өмнөөс өөр хүн гүйцэтгэж үл чадах үйл ажиллагаа (унтах, суралцах, өөрийгөө хөгжүүлэх, амрах) хамаарахгүй (заалт 6, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
2	Ажлын хэлбэр	Харилцан ялгаатай зорилгоор хийж гүйцэтгэдэг, өөр хоорондоо адилгүй 5 ажлын хэлбэрийг хэмждэг. Эдгээр ажлын хэлбэрүүдийг үйлдвэрлэлийнх нь зориулалт (өөрийн эцсийн хэрэглээ болон бусдын хэрэглээнд зориулж эдийн засгийн нэгжид)-аас болон үйл ажиллагааных нь шинж чанар (цалин хөлстэй, орлого олох эсэх)-аас хамаарч дараах байдлаар тус тусад нь хэмждэг. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил, 2. Цалин хөлс, орлого олох зорилготой гүйцэтгэсэн хөдөлмөр эрхлэлт, 3. Цалин хөлсгүй дадлагажих ажил 4. Сайн дурын ажил 5. Бусад үйл ажиллагаа. 6. (ХСОУ-ын 19-р, 20 бага хурлын тогтоол-1).
3	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил	Өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил гэж ихэвчлэн өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм (заалт 7а, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
4	Хөдөлмөр эрхлэлт (цалин хөлс, орлого олох зорилготой ажил)	Хөдөлмөр эрхлэлт гэж цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм. Хөдөлмөр эрхлэлт гэсэн ажлын хэлбэр нь ажиллах хүчний статистикийн хамрах хүрээг тогтооно (заалт 7b, 11, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
5	Цалин хөлсгүй дадлагажих ажил	Цалин хөлсгүй дадлагажих ажил гэж ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор цалин хөлсгүйгээр бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм (заалт 7с, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
6	Сайн дурын ажил	Сайн дурын ажил гэж заавал хийж гүйцэтгэх үүрэг хүлээгээгүй ч бусдын хэрэглээнд зориулан цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх албадлагын бус шинжтэй үйл ажиллагаа юм (заалт 7d, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
7	Бусад ажил	Бусад ажил гэж цалин хөлсгүй нийтийг хамарсан ажил, шүүх, түүнтэй адилтгах эрх мэдэл бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр цалин хөлсгүйгээр хийж гүйцэтгэх хоригдлуудын ажил, цэрэг, цагдаагийн байгууллагаас цалин хөлсгүй гүйцэтгүүлж буй ажил (бусдад хөлсгүй хийж өгсөн албадлагын шинж чанартай ажил) юм (заалт 8, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).
8	Үндсэн ажлын байр	Үндсэн ажлын байр гэж тухайн хүн цалин хөлс, орлого олох зорилгоор хоёр болон түүнээс дээш ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй тохиолдолд тухайн хугацаанд хамгийн их цаг зарцуулсан ажил юм (заалт 12b, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

9	Эдийн засгийн үйл ажиллагаа	Эдийн засгийн үйл ажиллагаа гэж зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, үндэсний тооцооны системийн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд худалдах, солилцох эсвэл өөрийн хэрэглээндээ зориулан өрхөд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хамруулна. Харин өөрийн хэрэглээндээ зориулсан үйлчилгээ болон бусдын хэрэгцээнд зориулсан сайн дурын үйлчилгээг хамруулахгүй.
10	Эдийн засгийн бус үйл ажиллагаа	Эдийн засгийн бус үйл ажиллагаа гэж Үндэсний тооцооны системийн хүрээнээс гаднах хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр өөрийн хэрэглээний болон бусдын хэрэглээнд зориулж сайн дураар хийж гүйцэтгэсэн үйлчилгээ юм.
Хүүхдийн хөдөлмөр		
11	Хүүхэд	Хүүхэд гэж НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйл болон ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар конвенцын 2 дугаар зүйлд зааснаар 18 насанд хүрээгүй хүнийг хүүхэд гэж тодорхойлно. Хүүхдийн хөдөлмөрийг хэмжих зорилтод хүн ам нь 5-17 насны бүлэгт багтах бүх хүүхэд байх бөгөөд хүүхдийн насыг түүний хамгийн сүүлчийн төрсөн өдрөөр тасалбар болгох буюу бүтэн насаар тодорхойлно (заалт 8, 9, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоол энэ 20-р өөрчлөгдөөгүй).
12	Хүүхдийн ажил эрхлэлт	Хүүхдийн ажил эрхлэлт гэж хүүхдийн хөдөлмөрийг хэмжихтэй холбоотой хамгийн өргөн хүрээтэй ойлголт бөгөөд ҮТС-2008-д тодорхойлсноор ҮТС-ийн үйл ажиллагааны ерөнхий хүрээнд хамаарч буй бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх аливаа үйл ажиллагааг тухайн хугацаанд нэг цагаас доошгүй эрхэлсэн 5-17 насны хүүхдийн үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, өөрийн хэрэглээний үйлчилгээ эрхэлж байгаа болон өрхийн хэрэгцээнд зориулан сайн дураар үйлчилгээ үзүүлж буй хүүхдийн үйл ажиллагааг ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнээс гадуурх ажлын хэлбэр гэж үзэх ч үйлдвэрлэлийн ерөнхий хүрээн доторх үйл ажиллагаа эрхэлж буй хүүхэд гэж үзнэ (заалт 11, 13 ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоолын шинэчилсэн төсөл).
13	Хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар	Хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар гэж ОУХБ-ын Ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцын 2 дугаар зүйлд зааснаар ажил, хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нь заавал эзэмших боловсрол буюу суурь боловсрол эзэмших хүүхдийн нас байх бөгөөд энэ нь ямар ч тохиолдолд 15 наснаас доошгүй байна.
